



## **ЗҮҮН БҮСИЙН СҮХБААТАР АЙМГИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

Тайлан бичсэн:

Ц.Баяртогтох

ЭША НСИСОУХ Антропологич

Улаанбаатар хот

2022 он

Энэхүү тайланг Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл Урлагийн газрын захилгаар “СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮЗЛЭГ, БҮСЧИЛСЭН СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗҮҮН БҮСИЙН ХЭЭРИЙН СУДАЛГАА” сэдэвт ажлын хүрээнд хийж гүйцэтгэв.

Судалгааны багийн ахлагч: Ц.Баяртогтох (ЭША, НСИСОУХ )

Судалгааны багийн гишүүд:

Пүрэвжав (ЭША, Түүх Угсаатан зүйн хүрээлэн),

Г.Болортуяа (Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн,

Сүхбаатар аймгийн соёл урлагийн газар),

Зураглаач: Б.Буянбат (Цахим суварга ТББ)

## **ГАРЧИГ УДИРТГАЛ**

### **I. Сүхбаатар аймагт ажилласан СББӨ-ийн улсын үзлэг, судалгааны тойм**

|  |    |
|--|----|
| 1.1 Зорилго  | 5  |
| 1.2 Сүхбаатар аймгийн соёлын биет бус өвийн судлагдсан байдлын товчоон                             | 6  |
| 1.3 Судалгааны ажлын маршрут болон хугацаа:  | 7  |
| 1.4 Судалгааны арга зүй  | 8  |
| 1.5 Сүхбаатар аймагт ажилласан СББӨ-ийн улсын үзлэг, судалгааны үр дүн (зорилго, зорилтын биелэлт) | 10 |

### **II. Сүхбаатар аймгийн СББӨ-д хийсэн цахим судалгааны (google forms) үзүүлэлт**

|   |    |
|---|----|
| 2.1 Сүхбаатар аймгийн СББӨ-д хийсэн цахим судалгааны тоон болон аналитик үзүүлэлт.                              | 11 |
| 2.2 Сүхбаатар аймгийн СББӨ-ийн ай, өвийн төрлүүдэд хийсэн судалгаа (сумдаар бичих, мөн өвийн зураглал орж ирнэ) | 29 |
| 2.3 Сүхбаатар аймгийн СББӨ-ийн үзлэг, судалгаанд оролцсон өвлөн уламжлагчид, товч танилцуулга                   | 30 |

### **III. Судалгаа, үйл ажиллагааны тайлан, дүгнэлт**

|   |    |
|---|----|
| 3.1 Сүхбаатар аймгийн СББӨ-ийн онцлох ай, өвийн төрлүүд                   | 50 |
| 3.2 Сүхбаатар аймгийн СББӨ-ийн онцлох өвлөн уламжлагчид                   | 50 |
| 3.3 Сүхбаатар аймгийн сббө-ийн улсын үзлэг, судалгааны урьдчилсан дүгнэлт | 63 |

**ЗӨВЛӨМЖ** **65**

**САНАЛ** **66**

**НОМ ЗҮЙ** **67**

**ХАВСРАЛТ** **68**

## УДИРТГАЛ

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.11 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, Соёлын сайдын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Зардал баталж, эрх шилжүүлэх тухай” А/218 дугаар тушаалыг үндэслэн “Соёлын биет бус өвийн үзлэг”, бүсчилсэн судалгааг зохион байгуулсан болно.

Сүхбаатар аймгийн түүхэн нөхцөл байдал онцолго хэв шинжийг дурдвал: Сүхбаатар аймаг нь хуучнаар Сэцэн хан аймгийн хошуу болон Дарьганга –ын хошуу нутагт харьяалагдаж байсан бөгөөд өнөөгийн Уулбаян, Түвшинширээ, Мөнххаан, Түмэнцогт, Сүхбаатар, Эрдэнэцагаан сум бүхлээрээ “Сэцэн хан” аймгийн зарим хошуудад, харин Уулбаян урд хэсэг, Түвшинширээ сумын бараг тэн хагас нь Баяндэлгэр, Халзан, Асгат, Дарьганга, Наран, Онгон сумын нутаг бүхлээрээ Дарьгангын хошуунд харьяалагдаж байжээ. Сүхбаатар аймаг Сэцэн хан аймгийн Ёст бэйс хошуу, Хурц ван, Эрдэнэдалай ван, Эрдэнэ гүний хошуу Дарьгангын таван сүрэгтэн хошуунаас анх эмхлэн байгуулагдаж, орчин үеийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж буюу аймаг, сум багийн зохион байгуулалтад орсныг тэмдэглүүштэй. *“Сүхбаатар аймгийн түүхэн товчоон 2022 он нэмэн засварласан 3 дахь хэвлэл”* Улсын бага хурлын 1943 оны 2-р сарын 20-ны өдрийн тогтоолоор Жавхлант шарга аймгийг их жанжин Сүхбаатарын нэрэмжит болгож “Сүхбаатар аймаг” гэж нэрлэх болсон. Мөн ондоо аймгийн төвийг Баруун-Урт голын дэргэд шилжүүлэн суурьшуулж “Баруун-Урт” гэж нэрлэсэн байна. Тус аймаг нь засаг захиргааны 13 сум, 66 багтай, 60 орчим мянган хүн амтай. Хүн амын олонх нь Халх, Дарьганга ястан бөгөөд Үзэмчин, Барга, Хуучид, Өөлд, Цахар ястан цөөнх хувийг эзэлдэг. *“[http://khural.mn/ Сүхбаатар аймгийн товч танилцуулга](http://khural.mn/)”*

1697 онд Чин улсын эзэн хааны зарлигаар Дарьгангад анх адуун сүргийг байгуулсан явдал юм. Тэгэхдээ халхын Сэцэн хан, Түшээт хан хоёр аймгийн зарим хошуудын нутгаас таслан авч Түшээт ханы засаг ноён Цэрэнжавыг харьяат албат нарынх нь хамт Дарьгангад ирүүлэн сүргийг хариуцуулсан ажээ. Дарьганга хошууны хүн ам нь 3 төрөл мал сүрэг захирах, адуулж маллах ба үйлчилгээний хүмүүсээс бүрдэх бөгөөд албаны хүмүүсийн эхнэр хүүхэд, эцэг эх болон албанд өртдөггүй хүмүүсийг сул хар гэдэг байв. Мөн Монголын бусад чуулган хошуудтай адил үе залгамжлах ноёд тайж, хамжлага гэж байгаагүй учир сүргийн хуяг байр зэрэг өндөр ба улсаас жил тутам цалин пүнлүү авдаг байв. *“Сүхбаатар аймгийн түүхэн товчоон 2022 он нэмэн засварласан 3 дахь хэвлэл”* Үүнээс улбаалан Сүхбаатар аймаг нь хурдан удмын адуу ихтэй, адууны соёл түгэн дэлгэрсэн нутаг. Монгол адуу маллах арга ухаан уяа сойлго таруулах, адууны эмээл хазаар урлал, суран эдлэл уяа зангилаа, марзай уртын дуугаар алдартай билээ.

Сүхбаатар аймгийн нутаг Дорнод Монголын тэгш талын өмнөд хэсгийн үргэлжлэл бөгөөд нийтдээ 82,3 мян.км 2 газар нутагтай, тал хээрийн бүсэд багтдаг. Нутгийн ихэнх хэсэг нь далайн түвшнээс дээш 1000-1200м өндөрт оршдог. Хамгийн өндөр цэг нь далайн түвшнээс дээш 1778 метрт өргөгдсөн Шилийн Богд уул, хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 790м-т өргөгдсөн Байшинт юм.

Сүхбаатар аймаг нь ус зүйн мужлалаар ус багатай бүст багтах бөгөөд гадаргуугийн ус ховортой, тогтмол урсгалтай гол мөрөн байхгүй боловч 20 гаруй жижиг нуур, 200-аад булаг шанд, гол горхи байдаг. "[http://khural.mn/ Сүхбаатар аймгийн товч танилцуулга](http://khural.mn/)" Тэгш тал хээр бэлчээр сайтай газар нутаг боловч усны нөөц баг сүүлийн жилээс өлийн цагаан оготно ихсэж бэлчээрт нөлөөлж байна.

## **I. Сүхбаатар аймагт ажилласан СББӨ-ийн улсын үзлэг, судалгааны тойм**

**1.1 Зорилго:** Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгааны хүрээнд соёлын биет бус өвийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах, тархалтыг тогтоох, үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулахад шаардлагатай мэдээлэл, хэрэглэгдэхүүн цуглуулахад оршино.

Судалгааны ажлын хүрээнд дараах зорилтын тавьсан болно. *Удирдамж 2.1-2.10*

- ❖ СББӨ-ийн уламжилсан байдал, шилжилт хөдөлгөөн, нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн нөхцөл байдлын судалгаа хийх;
- ❖ Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дүгээр тушаалаар баталсан Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өв, өвлөн уламжлагчийн талаар түүвэр судалгаа хийх;
- ❖ Тухайн орон нутагт оршин буй үндэстэн, угсаатны бүлэг, СББӨ-ийн төрөл зүйлийг таньж тогтоох, сурвалжлан олох;
- ❖ Соёлын биет бус өв, өв тус бүрийн хадгалалт хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж тогтоох, дүн шинжилгээ хийх;
- ❖ СББӨ болон өвлөн уламжлагчийн тоо, газарзүйн тархалтыг тогтоох;
- ❖ Тухайн орон нутагт СББӨ-ийн чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээний мэдээллийг цуглуулах;
- ❖ СББӨ-ийн үзлэг, судалгааны үр дүнгийн талаарх урьдчилсан дүгнэлт гаргах;
- ❖ Судалгаа хийсэн СББӨ-ийг төлөөллийн болон яаралтай хамгаалах жагсаалтад оруулах, хасах, хадгалан хамгаалах санал боловсруулах;
- ❖ Үзлэг, судалгааны мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулах;
- ❖ СББӨ, өвлөн уламжлагчийг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулж, Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг баяжуулах.


## **1.2 Сүхбаатар аймгийн соёлын биет бус өвийн судлагдсан байдлын товчоон**

“БНМАУ –ийн ястан угсаатнууд” Х Нямбуу 1992 он номд угсаатны бүлэг түүхийг талаар дурдсан бол, “БНМАУ-ийн угсаатан зүйн 1 дүгээр боть” 1987 он номд Халх угсаатан талаар, “БНМАУ-ийн угсаатан зүйн 3 дугаар боть” 1996 он номд Үзэмчин, Дарьганга угсаатны талаар тус тус бичжээ. “Монгол хэлний товч тайлбар” Я.Цэвэл 1966 он хэвлүүлсэн бөгөөд “Монгол хэлний нутгийн аялгуу судлал” Ж.Цолоо, Ж.Ганбаатар, С.Энхжаргал. 2009 он номд Дарьганга хэл аялгуу хэл зүйн талаар дурдаж “Дарьганга хэл аялгууны мянган толь” Ш.Чимэдцэеэ 2015 он мөн хэл аялгууны талаар толь гаргаж байжээ. “Дарьганга ардын аман зохиол” Г.Ловор, Г.Мэнд-Ооёо “Дариганга” А.Лувсандэндэв ардын аман зохион домог аман яриаг судлан хэвлүүлж байсан байна.

Дарьгангын түүхийг бичсэн бүтээлийг дурдвал “Дарьганга уулын хошууны хүн амын бүртгэл 1926 он”, “Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд” Т.Билэгсайхан 2020 он тус тус хэвлүүлсэн бөгөөд “Монголын эдийн соёл ардын урлагийн зүйлчилсэн тайлбар толь” Л.Сономцэрэн 1992он болон “Дарьгангын сувдан сондор” Г.Мэнд-Ооёо 1994 он бүтээл нь дархан урлалын талаар судлан үзсэн бол “Дарьгангын хурдан хүлгүүд” С.Мажигсүрэн 2004 он, “Уяа эвлэг, морь хурдан” А.Баярмагнай 2004 он, “Хүлэгчдийн нууц” Д.Даваахүү 1999 он, “Хүлгийн хийморьтой нутаг” Ч.Цэрэндорж 2005 он номуудад Сүхбаатар нутгийн хурдан удмын адууны соёл, хурдан морь уяа сойлго арга ухааны талаар бичсэн байна. “Монголын ёс заншлын их тайлбар толь” Бат-Ирээдүй 1999, “Монголын газар усны нэрийн домог” О.Сүхбаатар 2001 он, “Монголын тахилгат уул усны судар оршвой” О.Сүхбаатар номд Сүхбаатар аймгийн тахилгатай уул усны нэр, уул лусын тахилгын зан үйлийг талаар бичжээ.

### 1.3 Судалгааны ажлын маршрут болон хугацаа:

Сүхбаатар аймгийн хээрийн судалгааны баг 2022-10 дугаар сарын 14 ний өдрөөс 11 дүгээр сарын 4- ний өдөр дуустал 22 хоногийн хугацаанд ажилсан болно.



| СҮХБААТАР АЙМГИЙН СУМААР ЯВАХ МАШРУТ |               |        |             |
|--------------------------------------|---------------|--------|-------------|
| 1                                    | Баруун урт    | 60 км  | 10/14-10/16 |
| 2                                    | Сүхбаатар сум | 170 км | 10/16-10/17 |
| 3                                    | Эрдэнэцагаан  | 140 км | 10/17-10/19 |
| 4                                    | Дарьганга     | 60 км  | 10/19-10/21 |
| 5                                    | Онгон         | 100 км | 10/21-10/22 |
| 6                                    | Баяндэлгэр    | 80 км  | 10/22-10/23 |
| 7                                    | Түвшинширээ   | 80 км  | 10/24-10/26 |
| 8                                    | Уулбаян       | 80 км  | 10/26-10/27 |
| 9                                    | Халзан        | 80 км  | 10/27-10/28 |
| 10                                   | Баруун-Урт    | 140 км | 10/29-10/31 |
| 11                                   | Түмэнцог      | 150 км | 11/1-11/2   |
| 12                                   | Мөнххаан      | 60км   | 11/3-11/4   |

Хүснэгт -1

## 1.4 Судалгааны арга зүй

Удирдамжийн 5.6.1 СББӨ-ийн үзлэг, бүсчилсэн судалгааг зохион байгуулах “Хээрийн судалгааны баг” маршрутын дагуу томилолтоор ажиллахдаа түүврийн болон асуумжийн арга зүйг ашиглана хэмээн заасан болно. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн Сүхбаатар аймгийн соёлын биет бус өвийн бүртгэл мэдээллээс бүлэглэсэн түүвэр хийх аргаар нийт 11 сум тус бүрээр бүртгэлтэй өвийн төрөлд тулгуурлан түүвэрлэн сонгосон болно. Бүлэглэн түүвэр хийснээр сум тус бүрийн өвийн төрөл, өвлөн уламжлагч нарыг тодруулан харах боломжтой болж судалгааны үр нөлөө сайжирна хэмээн тооцсон болно. Бүлэглэн түүвэр хийж сонгосон өвийн төрөлд бүртгэлтэй өвлөн уламжлагч нартай асуумжийн арга, ганцаарчилсан ярилцлагын аргаар судалгаа хийсэн.

Түүвэр судалгааны арга зүйн дараах 2 төрөлтэй:

- ❖ Магадлалт бус түүвэр: сул тал нь аргуудын хувьд ямар нэгэн статистикийн онолын зааварчилгаа гэж байхгүй. Зөвхөн субъектив үнэлгээгээр үнэлэгддэг. Судалгааны үр дүн нь хазайлттай байх бөгөөд хазайлтын хэмжээ(ээрэг, сөрөг) мэдэгдэхгүй. Түүврийн бодит байдлын зэргийг тооцох боломжгүй. Зэргээс шалтгаалан энэ аргыг сонгоогүй болно.
- ❖ Магадлалт түүвэр: Нийт зорилтот эх олонлогоос түүврийг сонгодог . Түүврийн үр дүнгээр эх олонлогийн талаарх дүгнэлт гаргах боломжтой болдог . Түүврийн хазайлтыг бууруулдаг . Бодитой байдлыг хэмжих, түүврийн алдааг тооцох боломжтой. Судалгааны гаргасан үр дүнг хэрэглэгчид хүлээн зөвшөөрнө (бидний гол анхаарал хандуулах хэсэг) Магадлалт түүврийн аргууд дараах байдлаар ангилдаг. Энгийн санамсаргүй, Систем, (системчилсэн), Бүлэглэсэн, Хэмжээнд пропорциональ магадлалт (ХПМ), Кластер түүвэр,Олон шатат гм.
- ❖ Бүлэглэсэн түүвэр нь Эх олонлогийг нэмэлт үзүүлэлтийн (бүлэглэх үзүүлэлт) тусламжтайгаар хэсэг бүлэгт хуваасныг түүврийн бүлэг/strata/ хийх бөгөөд ингэснээр түүврийн үр нөлөө сайжирдаг. Сүхбаатар аймгийн улсын соёлын өвийн бүртгэл мэдээллийн санд бүртгэгдсэн нийт 7 ай савын 25 төрлийн соёлын өвийг 312 хүн өвлөн уламжлагчаас сум тус бүрээр бүлэглэн түүвэрлэн 79 хүнийг хамруулсан болно


| № | Судалгаанд хамрагдсан сумын нэр | Түүвэрт хамрагдсан өвлөн уламжлагчдын тоо | СӨҮТ Бүртгэлтэй өвлөн уламжлагчдын тоо | Сум тус бүр түүврийн хувь |
|---|---------------------------------|---|--|---------------------------|
| 1 | Сүхбаатар                       | 14  | 25                                     | 56 %                      |
| 2 | Эрдэнэцагаан                    | 9   | 45                                     | 40 %                      |
| 3 | Дарьганга                       | 8   | 27                                     | 29.6 %                    |
| 4 | Онгон                           | 5   | 19                                     | 26 %                      |
| 5 | Баяндэлгэр                      | 10  | 16                                     | 62.5 %                    |
| 6 | Түвшинширээ                     | 8   | 34                                     | 23.5 %                    |
| 7 | Уулбаян                         | 8   | 16                                     | 50 %                      |
| 8 | Халзан                          | 3   | 5                                      | 60 %                      |



|    |             |    |    |        |
|----|-------------|----|----|--------|
| 9  | Баруун –Урт | 7  | 15 | 46.6%  |
| 10 | Түмэнцогт   | 13 | 68 | 19.1 % |
| 11 | Мөнххаан    | 2  | 6  | 33 %   |
| 12 | Асгат,      | -  | 27 |        |
| 13 | Наран       | -  | 25 |        |

Хүснэгт 2

### Сүхбаатар аймгийн соёлын биет бус өвийн бүртгэл судалгааны ажилд сум тус бүр



**Асуулж судалгааны арга анкет:** Анкетын арга нь өвлөн уламжлагч нарын санаа бодол, хүсэл эрмэлзэл, хандлага үнэлгээг тодорхойлоход хамгийн тохиромжтой мэдээлэл цуглуулах үндсэн арга билээ анкетын судалгааны мэдээллийг PAPI rare and rep буюу нүүр тулсан хэлбэрээр авах бөгөөд анкетын судалгааны явцад илэрсэн онцлог кейс бүхий үнэ цэнтэй мэдээлэл өгөх респонденттэй ганцаарчилсан ярилцлага зохион байгуулна. Улсын соёлын өвийн бүртгэл мэдээллийн сан дахь Сүхбаатар аймгийн биет бус өвийн бүртгэлтэй 7 ай савын давхардсан тоогоор 25 төрлийн өвийг өвлөн уламжлагчаар бүртгэгдсэн 312 хүнээс түүврээр авсан 76 өвлөн уламжлагч тус бүрээс асуулгын судалгаа авсан болно. Үүний ярилцлагын аргаар нарийвчлан тодруулах судалгаа хийсэн болно.

**Ганцаарчилсан ярилцлагын арга:** Асуумжийн дараа Өвлөн уламжлагч нараас өвийн талаар мэдээллийг гүнзгийрүүлэн судлах, өвлөн уламжлагчийн болон орон нутгийн өнөөгийн нөхцөл байдал учир шалтгааныг тодруулах мэдээллүүдийг цуглуулна. Мөн чухал үнэ цэнтэй мэдээлэл цуглуулдаг, шинэ холбоо хамаарал чиг хандлага үзэл санааг илрүүлдэг мөн тухайн нөхцөлд

тохируулан асуултаа өөрчилж сонирхолтой хариултыг гүнзгийрүүлж тодруулах замаар асуултаа лавшруулах боломжтойгоор давуу талтай. Судалгааны үр дүнг нэгтгэхдээ *5.6.6. дурдсанчлан СББӨ-ийн оршин тогтнох чадавх, нөхцөл байдлын дүн шинжилгээ, задлан шинжилгээ хийхдээ тоон болон харьцуулалтын аргыг ашиглана*; тайланд тусгасан болно.

### **1.5 Сүхбаатар аймагт ажилласан СББӨ-ийн улсын үзлэг, судалгааны үр дүн (зорилго, зорилтын биелэлт)**

|       |  |   |
|-------|--|---|
| 1.5.1 | СББӨ-ийн уламжилсан байдал, шилжилт хөдөлгөөн, нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн нөхцөл байдлын судалгаа хийх;  | Сүхбаатар аймгийн байгаль орчин, нөөц баялаг, сумдын онцлог зэрэгтэй танилцаж мэдээлэл бүрдүүлсэн, СББӨ-ийн өмнөх цаг үеийн мэдээллүүдтэй танилцсан, 11 суманд ажиллаж сумдын СУГ, Соёлын төвийн удирдлага мэргэжилтнүүдтэй уулзаж өнөөгийн нөхцөл байдлын талаар тодруулга авч, заримд нь зөвлөгөө өгч ажиллав. СББӨ-ийн 79 өвлөн уламжлагчдаас цаасан болон цахим судалгааг авч бүртгэв |
| 1.5.2 | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Бүртгэл шинэчлэн батлах тухай” 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дүгээр тушаалаар баталсан Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өв, өвлөн уламжлагчийн талаар түүвэр судалгаа хийх; | -Үндэсний бүртгэлд шинээр нэмж оруулах болон зөрүүтэй байгаа хасах шаардлагатай /шилжсэн, нас барсан зэрэг/ өвлөн уламжлагчдын мэдээлэлтэй танилцах ажлыг хийв.<br>- Улсын бүртгэлд бүртгэгдсэн Сүхбаатар аймгийн нийт 312 өвлөн уламжлагчдаас 102 өвлөн уламжлагчийг түүвэрлэн үүнээс 79 өвлөн уламжлагч судалгаанд хамруулав.   |
| 1.5.3 | Тухайн орон нутагт оршин буй үндэстэн, угсаатны бүлэг, СББӨ-ийн төрөл зүйлийг таньж тогтоох, сурвалжлан олох;  | -Сүхбаатар аймгийн суманд оршин суудаг баримтжуулав.<br>-СББӨ-ийн өвлөн уламжлагч 5 хүнийг нэмж тодруулав.  |
| 1.5.4 | Соёлын биет бус өв, өв тус бүрийн хадгалалт хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж тогтоох, дүн шинжилгээ хийх;   | -СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдалд, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг google forms-оор тодруулав.<br>-Бид нийт 11 сумын соёлын төвийн удирдах хүмүүстэй уулзаж тодруулга авав.   |
| 1.5.5 | СББӨ болон өвлөн уламжлагчийн тоо, газарзүйн тархалтыг тогтоох;  | Тайлангийн 2-р бүлгийн 2.2, 2.3 үзнэ үү.  |
| 1.5.6 | Тухайн орон нутагт СББӨ-ийн чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээний мэдээллийг цуглуулах;  | 2022.04-ББӨ урлагийн бага наадам 13 сумын 400 өвлөн уламжлагч орсон,<br>2022.08-Нүүдэлчин монгол өв соёлын их наадам 61 өвлөн уламжлагч орсон,<br>2022.10-Хунгийн баяр Дарьганга 6 сумын  |

|        |  |   |
|--------|--|---|
|        | 2022 оны Биет бус өвийн талаар зохион байгуулсан арга хэмжээг дурдвал  | ардын авьяастнуудын тоглолт, гар урлалын үзэсгэлэн гаргав,<br>2022.11-Агтана хүрээт монгол адууны өв соёлын наадам Үзэмчин Дарьганга өв соёлын үзэсгэлэн дэлгэж оролцов.  |
| 1.5.7  | СББӨ-ийн үзлэг, судалгааны үр дүнгийн талаарх урьдчилсан дүгнэлт гаргах;   | Тайлангийн 3.3 дэд бүлгээс үзнэ үү.   |
| 1.5.8  | Судалгаа хийсэн СББӨ-ийг төлөөллийн болон яаралтай хамгаалах жагсаалтад оруулах, хасах, хадгалан хамгаалах санал боловсруулах; | Тайлангийн 3-дугаар бүлгийн 2-оос үзнэ үү.  |
| 1.5.9  | Үзлэг, судалгааны мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулах;   | Тайланд хавсаргав. Хуудас 51.   |
| 1.5.10 | СББӨ, өвлөн уламжлагчийг гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулж, Улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг баяжуулах.       | Нийт минут секундйн хугацаатай үргэлжлэх хэмжээтэй гэрэл зураг болон минут буюу цагийн хугацаатай үргэлжлэх 424 GB хэмжээтэй дүрс бичлэг гэрэл зургийн хамт бүрдүүлээ.<br>Зураг авалтад ашигласан тоног төхөөрөмж <ul style="list-style-type: none"> <li>• Дуу бичлэгийг Zoom H6 ашиглан MP3 форматаар</li> <li>• Дүрс бичлэгийг GoPro Hero 9, Nikon D850, Nikon D7000 ашиглан Full HD 1080 болон 4K нягтаршил бүхий MOV, MP4 форматаар</li> <li>• Гэрэл зургийг Nikon D850, Nikon D7000 ашиглан JPEG, RAW форматаар</li> </ul> ашиглан авлаа.<br>Эдгээр ажлын файлуудыг тухайн төхөөрөмжүүдийн дээд хүчин чадалд тулгаж авсан бөгөөд цаашид бүтээл болгон ашиглахад хангалттай өндөр чанартай болно.<br>Тайлангийн дагалдууллыг үзнэ үү. |

## **II. Сүхбаатар аймгийн СББӨ-д хийсэн цахим судалгааны (google forms) үзүүлэлт**

Сүхбаатар аймгийн СББӨ-ийн үзлэг баримтжуулалт судалгааны ажлын хүрээнд нийт 22 хоногийн хугацаанд 11 сумаар явж нийт 74 өвлөн уламжлагчийг бүртгэж үүнээс 5 өвлөн уламжлагчыцийг шинээр бүртгэн, 79 өвлөн уламжлагчийн 424 GB дүрс бичлэг, фото зураг баримтжуулалт хийсэн болно. Судалгаанд оролцсон өвлөн уламжлагч нарын бүртгэлийг хавсралтаар оруулсан болно.

### **2.1 Сүхбаатар аймгийн СББӨ-д хийсэн цахим судалгааны тоон болон аналитик үзүүлэлт**

Монгол Улсын нутагт амьдарч буй угсаатны бүлгийн соёлын биет бус өвийн өнөөгийн нөхцөл байдал, оршин тогтнох чадварыг тандан судлах, дүн шинжилгээ


хийх энэхүү судалгааны зорилгыг ойлгож, сайн дураар хүлээн зөвшөөрч, асуумжийг бөглөж ирүүлсэн.

Судалгааны нэгдүгээр хэсэг ерөнхий мэдээлэл.

**Судалгаанд оролцсон соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын хүйсийн байдал.**




**Судалгаанд оролцсон СББӨ-ийг өвлөн уламжлагчдын насны байдал.**




*Жич: залуучууд СББӨ-ийг өвлөн уламжлахгүй байгаа бус, 18 нас хүртэлх, 19-25 хүртэлх насны иргэд түүвэр судалгаанд хамраагүй болно.*


## Судалгаанд хамрагдсан СББӨ-ийг өвлөн уламжлагчийн боловсролын байдал




## Судалгаанд хамрагдсан СББӨ-ийг өвлөн уламжлагчийн хөдөлмөр эрхлэлтийн байдал



## Судалгаанд оролцогчдын орлогын эх үүсвэр



## Судалгаанд хамрагдсан СББӨ-ийг өвлөн уламжлагчдын үндэс, угсаа



Тухайн орон нутагт оршин буй үндэстэн, угсаатны бүлэг, СББӨ-ийн төрөл зүйлийг таньж тогтоох, сурвалжлан олох *“Удирдамжийн 2.3”*

Сүхбаатар аймгийн 2020 оны хүн амын тооллогын үр дүнд нийт хүн амын 59 хувь нь халх, 39 хувь нь Дарьганга угсаатан бүлэг бөгөөд үлдсэн хувь нь бусад угсаатны бүлэг байна. Сүхбаатар аймгийн 2020 оны хүн амын тооллогын үндэс угсаагаар харуулсан мэдээтэй харьцуулбал

ХҮСНЭГТ 1. СҮХБААТАР АЙМГИЙН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ХУВИАР, 2010, 2020 ОН



| Үндэс, угсаа           | 2010          |                 | 2020          |                 |
|------------------------|---------------|-----------------|---------------|-----------------|
|                        | Хүний тоо     | Дунд эзлэх хувь | Хүний тоо     | Дунд эзлэх хувь |
| <b>БҮГД</b>            | <b>50 935</b> | <b>100.0</b>    | <b>62 792</b> | <b>100.0</b>    |
| Халх                   | 28 609        | 56.2            | 37 401        | 59.6            |
| Казак                  | 6             | 0.0             | 15            | 0.0             |
| Дөрвөд                 | 24            | 0.0             | 120           | 0.2             |
| Буриад                 | 130           | 0.3             | 161           | 0.3             |
| Баяд                   | 64            | 0.1             | 161           | 0.3             |
| <b>Дарьганга</b>       | <b>21 500</b> | <b>42.2</b>     | <b>24 467</b> | <b>39.0</b>     |
| Урианхай               | 6             | 0.0             | 66            | 0.1             |
| Захчин                 | 5             | 0.0             | 32            | 0.1             |
| Дархад                 | 2             | 0.0             | 91            | 0.1             |
| Торгууд                | 20            | 0.0             | 10            | 0.0             |
| Өөлд                   | 17            | 0.0             | 16            | 0.0             |
| Мянгад                 | 4             | 0.0             | 17            | 0.0             |
| Барга                  | 22            | 0.0             | 28            | 0.0             |
| Үзэмчин                | 319           | 0.6             | 161           | 0.3             |
| Монголын харьяат бусад | 186           | 0.4             | 3             | 0.0             |
| Бусад үндэс, угсаатан  | 14            | 0.0             | 43            | 0.1             |

\* Гадаад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоо ороогүй

## СББӨ-ийн өвлөн уламжлагч нарын эрүүл мэндийн байдал

36.4 хувь эрүүл мэндэд анхаарч чаддаг гэсэн нь судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагч нарын насны бүтэцтэй шууд хамааралтай байна учир нь 39.8 хувь 60-80 настай иргэд 8.4 хувь нь 80 дээш насны тэтгэврийн иргэд учир эрүүл мэндийн байдалд анхаарал хандуулан тодорхой эрүүл мэндийн үйлчилгээг

тогтмол авдаг мөн СББӨ –ийн өвлөн уламжлагч нарын хөдөлмөр эрхлэлтийн байдлаас хамааралтай бөгөөд төрийн албан хаагч нар жил бүрийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилогоонд хамрагдаж буй тул эрүүл мэндийн байдал тодорхой хянаж чаддаг хэмээн хариулж байна харин эрүүл мэнддээ анхаардаггүй гэсэн хариултын голдуу малчид хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэд хариулсан нь анхаарал татаж байна





**Малчид эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдахгүй байх шалтгаан**

Сумын болон сум дундын эмнэлэг нь эрүүл мэндийн шатлалаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагад харьяалагдах бөгөөд төрөлжсөн мэргэжлийн эмч байхгүй, аймаг нийслэлийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн зөвлөмжийн дагуу тусламж үйлчилгээ үзүүлэн хяналтад авдаг байна, Аймгийн нэгдсэн эмнэлэг бол 2 дахь шатлалын эмнэлэгт тооцогдох бөгөөд төрөлжсөн мэргэжлийн үзлэг эмчилгээ үзүүлдэг, үүнд дотор, мэдрэл, ерөнхий мэс засал эх барих, эмэгтэйчүүд, гэмтэл, сэтгэц, нүд,чих хамар хоолой, халдварт өвчин үзлэг оношилгоо хийдэг байна. Сум, сум дундын эмнэлэг төрөлжсөн мэргэжлийн эмч байхгүй учир нарийн үзлэг шинжилгээ шаардлагатай иргэд аймгийн нэгдсэн эмнэлэгт урт оочир дараалал үүсдэг болно. Малчин иргэдийн хувьд ажил мэргэжлийн онцлогоос болон олон хоногоор оочирлох боломжгүй тул эрүүл

мэндийн урьдчилсан үзлэг оношилгоонд хамрагдах нь бага өвдсөн үедээ эсвэл хүндэрсэн үед эмнэлэгт үзүүлэх нь элбэг байдаг. Олон хоног хүлээхээс хувийн эмнэлэгт үзүүлэх нь илүү байдаг. **“2022 он Монгол улсын үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн хууль зүйн антропологийн судалгаа” Монголын криминологчдын холбоо**

**Судалгаанд оролцогчийн 1 удаа эрүүл мэндийн үйлчилгээ хэдэн төгрөгөөр авдаг байдал /79 хариултаас/**



Судалгаанд хамрагдсан хүний 20.5 хувь тусгай хэрэгцээт үйлчилгээ шаардлагатай гэсэн хариулт сонгосон нь соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч нарын насны бүтцээр 39.8 хувь нь 60-80 настай иргэд 8.4 хувь нь 80 дээш насны иргэд байсантай холбоотой юм Эсрэгээр судалгаанд хамрагдсан иргэдийн 31.2 хувь 46-60 хүртэлх насны 15.7 хувь 36-45 хүртэлх насны 13 хувь 26-35 насны иргэд учир тусгай хэрэгцээт үйлчилгээ шаардлагатай бус байна түүнчлэн тусгай хэрэгцээ



шаардлагатай иргэдийн 44.4 хувь нь тулгуур эрхтэн, 33.4 хараа 16.7 хувь нь сонсгол гэсэн нь насжилтаар хамааралтай тусгай хэрэгцээ болно.

### Судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагчдаас тусгай хэрэгцээт хүн байгаа талаар




Тусгай хэрэгцээт хүн ямар асуудалтай эсэх /16 хүний хариулт/

### 8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

Аймгийн хэмжээнд 2 672 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт суурин хүн амын 4.3 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 1 541 буюу 57.7 хувь нь эрэгтэй, 1 131 буюу 42.3 хувь нь эмэгтэйчүүд байна.


ЗУРАГ 9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН





Хүн ам орон сууцны улсын нэгдсэн тооллогын Сүхбаатар аймгийн дүн 2020 он

Статистик тоо баримттай харьцуулахад тулгуур эрхтэн 616 хамгийн өндөр, хараа 410, сонсгол 244 иргэн байна. Судалгаанд оролцогчдоос нийгмийн амьдралд чөлөөтэй оролцоход тусгай хэрэгцээний ямар нэгэн тохируулга шаардлагатай байгаа эсэх 10 тийм гэсэн байна.

**Ямар төрлийн тусгай хэрэгцээт тохируулга шаардлагатай байгаа эсэх /10 хариултаас/**



СББӨ болон өвлөн уламжлагчийн тоо, газарзүйн тархалтыг тогтоох “Удирдамжийн 2.5” асуулгын үр дүнг харахад Өвлөн уламжлагч нар нь тухайн 98 хувь нь аймгийн уугуул 75 хувь нь сумын уугуул иргэд байна Энэ үр дүнг 2020 оны улсын хүн амын нэгдсэн тооллогын дүнтэй харьцуулан үзсэн болно.



Сүхбаатар аймаг хүн амын шилжилт хөдөлгөөн нийт хүн амын 5 хувийг эзлэх бөгөөд 2020 оны байдлаар 24.3 пунктээр буурсан байна түүнчлэн бидний судалгаанд хамрагдсан иргэдийн 96,4 хувь аймгийн угуул ба 75,9 хувь сумын


уугуул иргэн байна. Мөн өвлөн уламжлагч нарын насны бүтцийн хувьд дунд идэр ахмад насны иргэд зонхилж буй тул шилжилт хөдөлгөөн маш бага ажиглагдаж байна.

Түүнчлэн сум хоорондын шилжилт хөдөлгөөн нь маш тогтвортой бөгөөд нийт иргэдийн 69.6 хувь нь 20 ба түүнээс дээш жил 17.4 хувь 6-10 хүртэлх жил гэсэн хариултыг сонгосон байна. СББӨ –ийн өвлөн уламжлагч нар харьцангуй шилжилт хөдөлгөөн бага тогтвортой харагдаж байна.

СББӨ болон өвлөн уламжлагчийн тоо, газарзүйн хувьд шинэ тархалт үүссэн эсэх тухай тогтооход энэхүү судалгаа асуумжийн үр дүнгээр илрэх боломжгүй ч Сүхбаатар аймагт бүртгэлтэй СББӨ-ийн өвлөн уламжлагч нарын бүртгэл дээр үндэслэн 2.3 дугаар хэсэгт зураглал гарсан харуулсан болно. Үүнд тусгагдаагүй бусад хүчин зүйл байна. Үндэсний хэмжээнд албан бус шилжилт хөдөлгөөн хийж буй иргэд хуучин бүртгэлээр харагдаж буйг анхаарах хэрэгтэй. Улсын нэгдсэн бүртгэлийн санд орон нутагт шинээр шилжин ирж байгаа иргэн өөрийн хүсэлтээр шилжин ирсэн бүртгэл хийх бөгөөд тухайн орон нутагт удаан хугацаанд амьдраагүй иргэн хүсэл илгээхгүй бол хасалт хийх боломжгүй.

*Бүртгэлээ хийлгэсэн өрхийн дөнгөж гуравны нэг нь л хуулийн хугацаанд багтаан бүртгүүлсэн байна. Байнгын болоод түр суурьшил өөрчлөгдөхөд, иргэн бүр тухайн орон нутгийн бүртгэлийн байгууллагад 7–10 хоногт багтан бүртгүүлэх ёстой. Судалгаанд хамрагдсан шилжигч өрхүүдээс, зөвхөн гуравны нэг нь энэ хугацаанд багтаж бүртгэлээ хийлгэсэн бол үлдсэн хэсэг нь 6 сар ба түүнээс дээш хугацааны дараагаар бүртгүүлсэн байна. “Монгол улс хүн амын дотоодын шилжилт хөдөлгөөний судалгаа 2018 он”*

СББӨ-ийн өвлөн уламжлагчийг бүртгэх ажилд орон нутгийн мэргэжилтнүүд аль болон нутгийн уламжлалт СББӨ бүртгэх орон нутгийн онцлог хэв шинжээр ялгарахыг илүүд үздэг учир аймаг сумын уугуул иргэн байх магадлал өндөр болох юм. **Судалгаанд оролцогч СББӨ-ийг өвлөн уламжлагчийн шилжиж ирээд амьдарч буй жилийн үзүүлэлт /22 хариултаас/**




СББӨ-ийн өвлөн уламжлагч нарын хувьд аймаг дотоодын шилжилд хөдөлгөөн 80 хувь 16 хүн улс хоорондын шилжилт хөдөлгөөн 0.5 хувь 1 хүн аймаг хоорондын шилжилт хөдөлгөөн 15 хувь 3 хүн гэхдээ Дорнод аймаг буюу хөрш аймагтай хийсэн шилжилт хөдөлгөөн байна.


**СББӨ-ийг өвлөн уламжлагч тухайн аймагт шилжин ирсэн шалтгаан /22 хариултаас/**






**СББӨ-ийг өвлөн уламжлагчийн бүртгэлд хэрхэн хамрагдсан бэ? /79 хариултаас/**



**Судалгаанд хамрагдсан СББӨ-ийг өвлөн уламжлагчийн төрийн өндөр дээд одон медалиар шагнагдсан байдал /79 хүн, олон хариулт сонгож болно. /**




**Судалгааны хоёрдугаар хэсэг: СББӨ-ийн оршин тогтнох чадварыг тодорхойлох судалгаа**



**Судалгаанд оролцогчийн соёлын биет бус өвийн авьяасаа өвлөн уламжилсан хэлбэрүүд /79 хариултаас/**




Өвлүүлэн уламжлуулсан байдал 76 хувь бөгөөд хойч үедээ өвлүүлэх ажлыг тогтмол хийдэг үү гэсэн асуултад 38 хувь тийм 30 заримдаа гэсэн байна үүнээс 70.5 хувь нь ахуй амьдрал дээр 9.7 хувь албан сургалтаар 14 хувь шавь сургалтаар гэж хариулсан байна.



Мөн судалгаанд хамрагдсан иргэдийн 73 хувь нь СББӨ –ийг үйлдэх хэв маяг өөрчлөгдөөгүй хэмээн хариулжээ.

Өвлөн уламжлуулдаг хэлбэр /61 хариултаас, хариултауд давхацсан байдлаар/




### СББӨ-ийн өвлөн уламжлагчдад шаардлагатай дэмжлэг юу вэ? гэсэн асуултад




Өвлөн уламжлагч нарын арга барил өөрчлөлт багатай дээр 2-3 үеийн өвлөн уламжлагч, 3 дээш үеийн өвлөн уламжлагч нарын 65 хувиас дээш буй залгамж халаа алдагдаагүй, бөгөөд өвлөн уламжлагч нар төрөөс дэмжлэг шаардлагатай хэмээн хариулжээ.

**Судалгааны гуравдугаар хэсэг: СББӨ-ийн хадгалалт, хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа**

СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалд байгалийн эергээр нөлөөлж буй нь



СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалд байгалийн сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс /72 хариултаас /





СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалд нийгмийн нөлөөллийн эерэг хүчин зүйлс /72 хариултаас /






СББӨ-ийн хадгалалт хамгаалалтын нөхцөл байдалд нийгмийн нөлөөллийн сөрөг хүчин зүйлс /75 хариултаас/



## Өвлөн уламжилж буй өв өрхийн эдийн засаг, санхүүд нөлөөлдөг байдал

СББӨ-ийн өвлөн уламжлагч нарын өрхийн эдийн засгийн нөхцөл байдал, санхүүд маш хангалттай нөлөөтэй гэсэн хүний тоо 3 бөгөөд хангалттай гэсэн хүний тоо 21 байгаа нь өвийн төрлөөс хамаарч байна. Хурдан морины уяа сойлго, Дархан урлал, модон сийлбэр, арьс шир суран эдлэл, эсгий ширмэл эдлэл, мал маллах арга ухаанаас голдуу эдийн засаг санхүүд нөлөөтэй гэсэн болон бусад аман илэрхийлэл ардын язгуур урлаг уламжлалт мэдлэг ухаантай холбоотой СББӨ –ийн өвлөн уламжлагч нарын хувьд нөлөө багатай юм


## Сүхбаатар аймагт СББӨ-ийг эдийн засгийн эргэлтэд оруулах эрэлт




## Угийн бичигтэй холбоотой асуулгын үр дүн




**Угийн бичиг хөтлөх арга ухаанаа өвлүүлэн уламжлуулдаг эсэх / 57 хариултаас /**




**Угийн бичгийг хөтөлж байгаа байдал /26 хариултаас/**



### Ямар хэлбэрээр угийн бичиг хөтөлж байгаа эсэх /26 хариултаас/



### Угийн бичиг хөтлөх уламжлалт мэдлэгийг хэнд өвлүүлэн уламжлуулж байгаа байдал /19 хариултаас, олон хариулт сонгож болно.



Улсын их хурлын 2004 оны 21 дүгээр тогтоол “Монгол улсын төрөөс хүн амын талаар баримтлах бодлого”-ын 3.1.8 Соёлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь заалт, Гэр бүлийн тухай хуулийн 10.4-ыг үндэслэн Монгол улсын засгийн газрын 2007 оны 10 сарын 3 өдрийн тогтоолоор Угийн бичиг хөтлөх журмыг шинэчлэн баталсан бөгөөд 2008 онд Боловсрол соёл шинжлэх ухааны сайд Ө Энхтүвшин тушаалаар үлгэрчилсэн загвар боловсруулан хэрэгжүүлсэн болно. Үүний үр дүнд Сүхбаатар аймгийн сумдаар угийн бичиг хөтлөх тухай сургалт зохион байгуулсан бөгөөд үүний үр дүнд Угийн бичиг хөтөлдөг иргэдийн тоо тодорхой хэмжээнд өссөн болно .

**2.2 Сүхбаатар аймгийн СББӨ-ийн ай, өвийн төрлүүдэд хийсэн судалгаа (сумдаар бичих, мөн өвийн зураглал орж ирнэ)**

Сүхбаатар аймгийн СББӨ-ийн бүртгэл мэдээллийг хамрагдсан 11 сум 7 ай сав тус бүрээр нь авч үзвэл Сүхбаатар-23, Эрдэнэцагаан-83, Дарьганга-30, Онгон-28, Баяндэлгэр-18, Түвшинширээ-34, Түмэнцогт-85, Баруун-Урт-13, Халзан-20, Уулбаян-22, Мөнххаан-11 бүртгэлтэй байна.

| №  | Сумдын нэрс  | Соёлын биет бус өвийн 7 ай сав      |                    |   |   |                      |                       |                     |
|----|--------------|-------------------------------------|--------------------|---|---|----------------------|-----------------------|---------------------|
|    |              | Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд | Ардын язгуур урлаг | Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа, дуудлага | Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, зан үйл | Уламжлалт арга ухаан | Мал маллах арга ухаан | Уламжлалт гар урлал |
| 1  | Сүхбаатар    |                                     | 11                 | 3   | 4   | 5                    |                       | 7                   |
| 2  | Эрдэнэцагаан | 4                                   | 32                 | 6   |   | 8                    | 27                    | 6                   |
| 3  | Дарьганга    | 4                                   | 16                 |   |   |                      | 3                     | 7                   |
| 4  | Онгон        | 2                                   | 7                  | 10  | 2   | 3                    |                       | 4                   |
| 5  | Баяндэлгэр   | 1                                   | 8                  |   | 1   | 3                    | 2                     | 3                   |
| 6  | Түвшинширээ  | 2                                   | 4                  |   | 1   | 2                    | 15                    | 10                  |
| 7  | Түмэнцогт    | 8                                   | 34                 | 7   | 4   | 10                   | 3                     | 19                  |
| 8  | Баруун-Урт   | 1                                   | 7                  |   |   |                      |                       | 5                   |
| 9  | Халзан       |                                     | 9                  |   |   |                      | 6                     | 5                   |
| 10 | Уулбаян      | 1                                   | 9                  | 1   |   | 4                    | 5                     | 2                   |
| 11 | Мөнххаан     | 5                                   |                    | 3   |   | 3                    |                       |                     |

*Сүхбаатар аймгийн соёл өвийн мэргэжилтэн Г Болортуяа*


Үзлэгт хамрагдсан Сүхбаатар аймгийн Соёлын биет бус өвийн төрлийг хүснэгтээр харуулбал

| Дд | Соёлын биет бус өвийн 7 ай сав      | Өвийн төрөл   | Өвийн тоо |
|----|-------------------------------------|---|-----------|
| 1  | Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд | Аман аялгуу – 2 ,<br>Бүүвэйн дуу - 1,<br>Бэлэг дэмбэрэлийн үгс 1 ,<br>Ерөөл 2,<br>Үлгэр 1,<br>Хэлц хэвшмэл үг 1,<br>Дом - 2 | 8         |
| 2  | Ардын язгуур урлаг                  | Дарьганга богино дуу - 2, Морин хуурын уламжлалт урлаг – 6, Цохилуур хөгжим тоглох урлаг 2 , Лимбэ хөгжим тоглох урлаг-     | 11        |

|   |  |  |           |
|---|--|--|-----------|
|   |  | 1 , Үзмэчин-Дарьганга уртын дуу-1, Үзэмчин богино дуу - 1, Халх богино дуу-1, Халх уртын дуу-1, Хурдан морины хүүхдийн гийнгоо, марзай – 1, Хуучир хөгжим тоглох урлаг 1, , Шударга хөгжим тоглох урлаг -1, Ятга хөгжим тоглох урлаг 1 ,   |           |
| 3 | Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага | Язгуур шүтлэг ёс, зан үйл, Монгол хөлөгт ба өрөгт тоглоомын уламжлалт төрлүүд - 1, Шагайн харваа - 1   | 4         |
| 4 | Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл            | Хурдан морь сойх, уралдуулах мэдлэг -2, Байгаль хамгаалах уламжлалт арга мэдлэг зан үйл, Зурхай - 1  | 2         |
| 5 | Уламжлалт гар урлал  | Халх хувцасны уламжлалт урлаг - 3, Эсгий ширмэл урлал - 4, Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал - 4, Монгол дархны уламжлалт арга ухаан - 5, Модон сийлбэр - 3, Монгол зургийн урлал - 3, Ноос, ноолуур боловсруулах уламжлалт арга - 1  | 7         |
| 6 | Мал маллах арга ухаан  | Тэмээн сүрэг маллах арга ухаан - 1, Адуун сүрэг маллах арга ухаан - 1, Үхэр сүрэг маллах арга ухаан – 3  | 3         |
| 7 | Уламжлалт арга ухаан   | Ардын сурган хүмүүжүүлэх ухаан -1, Арьс шир боловсруулах арга - 1, Мал хатгах уламжлалт мэдлэг - 1, Монгол уламжлалт цай ундаа хийх арга / жилийн цай/ - 1, Төл мал авахуулах уламжлалт мэдлэг ухаан - 1, Ургамалын зүйлээр анагаах ухаан хавсарсан өв - 2, Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга ухаан - 1 | 6         |
|   | <b>Нийт</b>  |  | <b>41</b> |

### 2.3 Сүхбаатар аймгийн СББӨ-ийн үзлэг, судалгаанд оролцсон өвлөн уламжлагчид, товч танилцуулга

Баруун-Урт сум

| № | Видео бичлэг гэрэл зургийн код | Өвлөн уламжлагчийн овог нэр | Ай сав/ өвийн төрөл  | Өвлөн уламжлагчийн гэрэл зураг  |
|---|--------------------------------|-----------------------------|--|---|
| 1 | СБ-001-БУ                      | Нацаг Амартайван            | Ай сав: Уламжлалт гар урлал<br>Өвийн нэр: Монгол дархны уламжлалт арга ухаан<br>3 дахь үеийн өвлөн уламжлагч |  |

|   |           |                        |  |   |
|---|-----------|------------------------|--|---|
| 2 | СБ-002-БУ | Чулуунбаатар<br>Энхтөр | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр: Модон<br>сийлбэрийн урлал   |    |
| 3 | СБ-003-БУ | Ёндон<br>Бадарч        | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр: Монгол<br>зургийн урлал<br>Баримтжуулсан тухай<br>мэдээлэл: Монгол<br>зургийн урлал |    |
| 4 | СБ-004-БУ | Жамсран<br>Уранбилэг   | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр: Монгол<br>дархны уламжлалт<br>арга ухаан<br>Батноров хийцээр<br>мөн урлал хийдэг    |   |
| 5 | СБ-005-БУ | Жалхаа<br>Бавгар       | Ай сав: Ардын язгуур<br>урлаг<br>Өвийн нэр: Дарьганга<br>богино дуу  |  |
| 6 | СБ-006-БУ | Лувсан<br>Цэдэвсүрэн   | Ай сав: Ардын язгуур<br>урлаг<br>Өвийн нэр: Морин<br>хуур хөгжмийн<br>уламжлалт урлаг  |  |



## Баяндэлгэр сум

|    |           |                            |  |   |
|----|-----------|----------------------------|--|---|
| 7  | СБ-007-БД | Галсан<br>Төмөрхуяг        | Ай сав: Уламжлалт<br>арга ухаан<br>Өвийн нэр: Ардын<br>сурган хүмүүжүүлэх<br>ухаан   |    |
| 8  | СБ-008-БД | Сундуй<br>Цэнд             | Ай сав: Ардын язгуур<br>урлаг<br>Өвийн нэр: Морин<br>хуур хөгжмийн<br>уламжлалт урлаг  |    |
| 9  | СБ-009-БД | Гончигсүрэн<br>Гунаасүрэн  | Ай сав: Эх хэл, аман<br>уламжлал,<br>илэрхийллүүд<br>Өвийн нэр: Үлгэр  |   |
| 10 | СБ-010-БД | Фушкин<br>Амгаланбаатар    | Ай сав: Уламжлалт<br>арга ухаан<br>Өвийн нэр: Мал<br>хатгах уламжлалт<br>мэдлэг ухаан<br><br>Шинээр бүртгэж<br>оруулсан.   |  |
| 11 | СБ-011-БД | Дамбийжанцан<br>Пүрэвсүрэн | Ай сав: Мал маллах<br>арга ухаан<br>Өвийн нэр: Адуун<br>сүрэг маллах арга<br>ухаан<br>Баримтжуулсан<br>тухай мэдээлэл:<br>Адуун сүрэг маллах<br>арга ухаан, Хурдан<br>морь шинжих уяа<br>сойлго. |  |




|    |           |                      |   |  |
|----|-----------|----------------------|---|--|
| 12 | СБ-012-БД | Чулуунхүү<br>Буянхүү | Ай сав: Мал маллах<br>арга ухаан<br>Өвийн нэр: Үхэр<br>сүрэг маллах арга<br>ухаан   |   |
| 13 | СБ-013-БД | Манлай<br>Шагдаржав  | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр: Монгол<br>зургийн урлал  |   |
| 14 | СБ-014-БД | Гаваа<br>Даамаа      | Ай сав: Уламжлалт<br>арга ухаан<br>Өвийн нэр:<br>Ургамлын зүйлээр<br>анагаах арга ухаан<br>Баримтжуулсан<br>тухай мэдээлэл<br>Ургамалын зүйлээр<br>анагаах ухаан,<br>уламжлалт бариа<br>засал |  |

### Дарьганга сум

|    |           |                     |  |   |
|----|-----------|---------------------|--|---|
| 15 | СБ-015-ДГ | Ням<br>Буяндэлгэр   | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр: Модон<br>сийлбэрийн урлал   |  |
| 16 | СБ-016-ДГ | Ядам<br>Төмөрчулуун | Ай сав: Уламжлалт<br>арга ухаан<br>Өвийн төрөл:<br>Мал хатгах<br>уламжлалт мэдлэг<br><br>Шинээр бүртгэлд<br>оруулсан |  |



|    |           |                           |   |   |
|----|-----------|---------------------------|---|---|
| 17 | СБ-017-ДГ | Батсүх<br>Мөнхсайхан      | Ай сав: Уламжлалт гар урлал<br>Өвийн нэр: Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал  |    |
| 18 | СБ-18-ДГ  | Сумьяа<br>Урансайхан      | Ай сав: Уламжлалт гар урлал<br>Өвийн нэр: Халх хувцасны уламжлалт урлал   |    |
| 19 | СБ-19-ДГ  | Борхүү<br>Энхмаа          | Ай сав: Уламжлалт гар урлал<br>Өвийн нэр: Монгол зургийн урлал  |   |
| 20 | СБ-020-ДГ | Давхай<br>Дугарсүрэн      | Ай сав: Уламжлалт арга ухаан:<br>Өвийн нэр: Ургамалын зүйлээр анагаах арга ухаан<br>Баримтжуулсан тухай мэдээлэл: Ургамалын зүйлээр анагаах арга ухаан хавсарсан өв<br>Монгол дархны уламжлалт арга ухаан |  |
| 21 | СБ-021-ДГ | Зундуй Боргил<br>Баттулга | Ай сав: Мал маллах арга ухаан<br>Өвийн нэр: Тэмээн сүрэг маллах арга ухаан<br>Шинээр бүртгэлд оруулсан  |  |

|    |           |                    |  |   |
|----|-----------|--------------------|--|---|
| 22 | СБ-022-ДГ | Дондов<br>Батхүрэл | Ай сав: Уламжлалт<br>арга ухаан<br>Өвийн нэр: Монгол<br>дархны уламжлалт<br>арга ухаан |  |
|----|-----------|--------------------|--|---|

### Мөнххаан сум


|    |           |                     |   |  |
|----|-----------|---------------------|---|--|
| 23 | СБ-023-МХ | Арилд Ганбаяр       | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр: Монгол<br>дархны уламжлалт<br>арга ухаан |   |
| 24 | СБ-024-МХ | Сэнгээ<br>Бат-Орших | Ай сав: Ардын язгуур<br>урлаг<br>Өвийн нэр: Морин<br>хуур хөгжмийн<br>уламжлалт урлаг |  |

### Онгон сум

|    |          |                       |   |   |
|----|----------|-----------------------|---|---|
| 25 | СБ-025-О | Мажиграгчаа<br>Улаан  | Ай сав: Ардын язгуур<br>урлаг<br>Өвийн нэр:<br>Дарьганга богино<br>дуу                                |  |
| 26 | СБ-026-О | Дорждэрэм<br>Тэгшбаяр | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр:<br>Монголын<br>уламжлалт арьс<br>ширэн эдлэлийн<br>урлал |  |

|    |          |                       |   |  |
|----|----------|-----------------------|---|--|
| 27 | СБ-027-О | Дашдорж<br>Ногоондарь | Ай сав: Уламжлалт<br>баяр наадам, зан<br>үйл, ёс, тоглоом<br>наадгай, уриа<br>дуудлага<br>Өвийн нэр: Төл<br>авахуулах ая<br>дуудлага, зан үйл |   |
| 28 | СБ-028-О | Цэвээн Юмжир          | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр: Халх<br>хувцасны уламжлалт<br>урлал  |   |
| 29 | СБ-029-О | Цэнд Нарантуяа        | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр: Эсгий<br>ширмэл урлал  |  |

### Сүхбаатар сум

|    |           |                           |   |   |
|----|-----------|---------------------------|---|---|
| 30 | СБ-030-СБ | Цэрэнбалтав<br>Сайнжаргал | Ай сав: Ардын язгуур<br>урлаг<br>Өвийн нэр: Халх<br>богино дуу              |  |
| 31 | СБ-031-СБ | Бүргэдэй<br>Эрдэнэчимэг   | Ай сав: Ардын язгуур<br>урлаг<br>Өвийн нэр: Цохилуур<br>хөгжим тоглох урлаг |  |



|    |           |                      |  |   |
|----|-----------|----------------------|--|---|
| 32 | СБ-32-СБ  | Балжинням<br>Амарбат | Ай сав: Уламжлалт<br>арга ухаан<br>Өвийн нэр: Арьс,<br>шир боловсруулах<br>арга  |    |
| 33 | СБ-033-СБ | Батдорж<br>Ганбаатар | Ай сав: Уламжлалт<br>арга ухаан<br>Өвийн нэр: Мал<br>хатгах уламжлалт<br>мэдлэг  |    |
| 34 | СБ-034-СБ | Лэгцэг<br>Нарангэрэл | Ай сав: Ардын язгуур<br>урлаг<br>Өвийн нэр: Шударга<br>хөгжим тоглох урлаг   |   |
| 35 | СБ-035-СБ | Буд<br>Цэнд          | Ай сав: Уламжлалт<br>баяр наадам, зан<br>үйл, ёс, тоглоом<br>наадгай, уриа<br>дуудлага<br>Өвийн нэр: Хөлөгт<br>ба өрөгт тоглоомын<br>уламжлалт төрлүүд |  |
| 36 | СБ-036-СБ | Чинжээ<br>Амаржаргал | Ай сав: Ардын язгуур<br>урлаг<br>Өвийн нэр: Халх<br>уртын дуу  |  |

|    |          |                           |   |  |
|----|----------|---------------------------|---|--|
| 37 | СБ-37-СБ | Ядамсүрэн<br>Цолмонсүрэн  | Ай сав: Уламжлалт<br>арга ухаан<br>Өвийн нэр: Цагаан<br>идээ бэлтгэх<br>уламжлалт арга        |   |
| 38 | СБ-38-СБ | Гонгорсүрэн<br>Баярмандах | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр: Халх<br>хувцасны уламжлалт<br>урлал              |   |
| 39 | СБ-39-СБ | Чүлтэм Батхүрэл           | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр:<br>Монголын<br>уламжлалт модон<br>эдлэлийн урлал |  |




### Түвшинширээ сум

|    |           |                              |   |   |
|----|-----------|------------------------------|---|---|
| 40 | СБ-040-ТШ | Жамъяанпунцаг<br>Должинсүрэн | Ай сав: Эх хэл, аман<br>уламжлал,<br>илэрхийллүүд<br>Өвийн төрөл: Дом         |  |
| 41 | СБ-041-ТШ | Жигжидсүрэн<br>Жамсран       | Ай сав: Уламжлалт<br>арга ухаан<br>Өвийн нэр: Морин<br>хуур хөгжмийн<br>урлал |  |

|    |           |                           |  |   |
|----|-----------|---------------------------|--|---|
| 42 | СБ-042-ТШ | Батсүх<br>Санжаа          | Ай сав: Эх хэл, аман<br>уламжлал,<br>илэрхийллүүд<br>Өвийн нэр: Аялгуут<br>үгс   |    |
| 43 | СБ-043-ТШ | Гомбо<br>Төмөрсүх         | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр: Халх<br>хувцасны уламжлалт<br>урлал   |    |
| 44 | СБ-044-ТШ | Равсал<br>Отгончимэг      | Ай сав: Мал маллах<br>арга ухаан<br>Өвийн нэр: Үхэр<br>сүрэг маллах арга<br>ухаан  |   |
| 45 | СБ-045-ТШ | Довдондамба<br>Дэчинганаа | Ай сав: Байгалийн<br>болон сав шим<br>ертөнцийн тухай<br>мэдлэг, зан үйл<br>Өвийн нэр: Байгаль<br>хамгаалах<br>уламжлалт арга<br>мэдлэг, зан үйл |  |
| 46 | СБ-046-ТШ | Дашзэвэг<br>Далайжаргал   | Ай сав: Мал маллах<br>арга ухаан<br>Өвийн нэр: Үхэр<br>сүрэг маллах арга<br>ухаан  |  |





|    |           |                            |  |   |
|----|-----------|----------------------------|--|---|
| 47 | СБ-047-ТШ | Төмөрбаатар<br>Хишигдүүрэн | Ай сав: Уламжлалт<br>арга ухаан<br>Өвийн нэр Эсгий<br>хийх уламжлалт арга      |  |
| 48 | СБ-048-ТШ | Базаррагчаа<br>Энхжаргал   | Ай сав: Уламжлалт<br>арга ухаан<br>Өвийн нэр: Мал<br>хатгах уламжлал<br>мэдлэг |  |

### Түмэнцогт сум


|    |           |                       |  |   |
|----|-----------|-----------------------|--|---|
| 49 | СБ-049-ТЦ | Дорж<br>Наранцэцэг    | Ай сав: Ардын<br>язгуур урлаг<br>Өвийн нэр: Ятга<br>хөгжим тоглох урлаг                  |   |
| 50 | СБ-045-ТЦ | Ишээхүү<br>Батгэрэл   | Ай сав: Ардын<br>язгуур урлаг:<br>Өвийн нэр Дархад-<br>Дарьганга уртын дуу               |  |
| 51 | СБ-051-ТЦ | Балдан<br>Хүрэлбаатар | Ай сав: Эх хэл, аман<br>уламжлал,<br>илэрхийллүүд<br>Өвийн нэр: Бэлэг<br>дэмбэрэлийн үгс |  |




|    |           |                            |  |   |
|----|-----------|----------------------------|--|---|
| 52 | СБ-052-ТЦ | Цэгмэд<br>Даваа            | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр: Эсгий<br>ширмэл урлал   |    |
| 53 | СБ-053-ТЦ | Жамъяндаваг<br>Эрдэнэтовуу | Ай сав: Мал маллах<br>арга ухаан<br>Өвийн нэр: Ямаан<br>сүрэг маллах арга<br>ухаан   |    |
| 54 | СБ-054-ТЦ | Шаравнямбуу<br>Оюун        | Ай сав: Байгалийн<br>болон сав шим<br>ертөнцийн тухай<br>мэдлэг, зан үйл<br>Өвийн нэр: Тэнгэр,<br>эрхэс, цаг агаар<br>шинжих мэдлэг<br>ухаан |   |
| 55 | СБ-055-ТЦ | Буд<br>Зоригтбаатар        | Ай сав: Эх хэл, аман<br>уламжлал,<br>илэрхийллүүд<br>Өвийн нэр:<br>Дайралцаа үг  |  |
| 56 | СБ-056-ТЦ | Жамсран<br>Наранцэцэг      | Ай сав: Ардын<br>язгуур урлаг<br>Өвийн нэр: Шудрага<br>хөгжим тоглох урлаг   |  |

|    |           |                          |   |   |
|----|-----------|--------------------------|---|---|
| 57 | СБ-057-ТЦ | Аюуш<br>Баатархуяг       | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр: Модон<br>сийлбэрийн урлал                      |    |
| 58 | СБ-058-ТЦ | Зана<br>Гомбо            | Ай сав: Ардын<br>язгуур урлаг<br>Өвийн нэр: Морин<br>хуур хөгжмийн<br>уламжлалт урлаг       |    |
| 59 | СБ-059-ТЦ | Ч Жанжаа                 | Ай сав: Ардын<br>язгуур урлаг<br>Өвийн нэр: Бүүвэйн<br>дуу                                  |   |
| 60 | СБ-060-ТЦ | Мягмаржав<br>Бямбарагчаа | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр:<br>Монголын<br>уламжлалт уях<br>зангидах урлал |  |

### Уулбаян сум

|    |           |                         |   |   |
|----|-----------|-------------------------|---|---|
| 61 | СБ-061-УБ | Доржготов<br>Ичинхорлоо | Ай сав: Эх хэл, аман<br>уламжлал,<br>илэрхийллүүд<br>Өвийн нэр: Дом |  |
|----|-----------|-------------------------|---|---|






|    |           |                           |  |   |
|----|-----------|---------------------------|--|---|
| 62 | СБ-062-УБ | Наваандорж<br>Лувсанцэрэн | Ай сав: Ардын<br>язгуур урлаг:<br>Өвийн нэр: Үзэмчин<br>- Дарьганга уртын<br>дуу   |    |
| 63 | СБ-063-УБ | Ч.Дэнсмаа                 | Ай сав: Уламжлалт<br>гар урлал<br>Өвийн нэр: Эсгий<br>ширмэл урлал   |    |
| 64 | СБ-064-УБ | Жамсран<br>Соёлсүх        | Ай сав: Ардын<br>язгуур урлаг<br>Өвийн нэр: Халх<br>уртын дуу  |   |
| 65 | СБ-065-УБ | Бадам /Шарав/<br>Агваан   | Ай сав: Байгалийн<br>болон сав шим<br>ертөнцийн тухай<br>мэдлэг, зан үйл<br>Өвийн нэр: Хурдан<br>морь сойх,<br>уралдуулах мэдлэг |  |
| 66 | СБ-066-УБ | Даваа<br>Жигмэджамц       | Ай сав: Байгалийн<br>болон сав шим<br>ертөнцийн тухай<br>мэдлэг, зан үйл<br>Өвийн нэр: Монгол<br>зурхай                          |  |
| 67 | СБ-067-УБ | Дондог<br>Шижирбаатар     | Ай сав: Уламжлалт<br>баяр наадам, зан<br>үйл, тоглоо наадгай<br>уриа дуулага<br>Өвийн нэр: Шагайн<br>харваа                      |  |


Халзан сум

|    |          |                     |  |   |
|----|----------|---------------------|--|---|
| 68 | СБ-068-Х | Халзан<br>Отгонтөгс | Ай сав: Ардын<br>язгуур урлаг<br>Өвийн нэр: Хурдан<br>морины хүүхдийн<br>гийнгоо, марзай |  |
| 69 | СБ-069-Х | Балдан<br>Махгал    | Ай сав: Ардын<br>язгуур урлаг<br>Өвийн нэр: Морин<br>хуур хөгжмийн<br>уламжлалт урлаг    |  |
| 70 | СБ-070-Х | Ганхүү<br>Мөнхөө    | Ай сав: Эх хэл, аман<br>уламжлал,<br>илэрхийллүүд<br>Өвийн нэр: Ерөөл                    |  |

**Эрдэнэцагаан сум**


|    |           |                         |  |   |
|----|-----------|-------------------------|--|---|
| 71 | СБ-071-ЭЦ | Жүгдэр<br>Сэнгээ        | Ай сав: Ардын<br>язгуур урлаг<br>Өвийн нэр: Хуучир<br>хөгжим тоглох<br>урлаг |  |
| 72 | СБ-072-ЭЦ | Алтангэрэл<br>Оюунгэрэл | Ай сав: Ардын<br>язгуур урлаг<br>Өвийн нэр: Үзэмчин<br>богино дуу            |  |
| 73 | СБ-073-ЭЦ | Бат-Өлзий<br>Батхолбоо  | Ай сав: Эх хэл,<br>аман уламжлал,<br>илэрхийллүүд<br>Өвийн нэр: Ерөөл        |  |

|    |           |                      |   |   |
|----|-----------|----------------------|---|---|
| 74 | СБ-074-ЭЦ | Мишигдорж<br>Ганболд | Ай сав: Ардын<br>язгуур урлаг<br>Өвийн нэр: Лимбэ<br>хөгжим тоглох<br>урлаг   |    |
| 75 | СБ-075-ЭЦ | Чойнжоо<br>Цолмон    | Ай сав: Уламжлалт<br>арга ухаан<br>Өвийн нэр: Арьс,<br>шир боловсруулах<br>уламжлалт арга   |    |
| 76 | СБ-076-ЭЦ | Банзрагч<br>Мишиг    | Ай сав: Уламжлалт<br>баяр наадам, зан<br>үйл, ёс, тоглоом<br>наадгай, уриа<br>дуудлага<br>Өвийн нэр: Төл<br>авахуулах ая<br>дуудлага, зан үйл |   |
| 77 | СБ-077-ЭЦ | Дамиран<br>Мөнхөө    | Ай сав: Уламжлалт<br>баяр наадам, зан<br>үйл, ёс, тоглоом<br>наадгай, уриа<br>дуудлага<br>Өвийн нэр:<br>Дарьганга хуримын<br>ёс, зан үйл      |  |
| 78 | СБ-078-ЭЦ | Ундрах<br>Уртнаст    | Ай сав: Уламжлалт<br>арга ухаан<br>Өвийн нэр: Монгол<br>үндэсний<br>уламжлалт, цай<br>ундаа хийх арга   |  |


|    |           |          |   |   |
|----|-----------|----------|---|---|
| 79 | СБ-079-ЭЦ | Аюуш Буд | Ай сав: Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд<br>Өвийн нэр: Хэлц хэвшмэл үг |  |
|----|-----------|----------|---|---|

Сүхбаатар аймгийн СББӨ-ийн өвлөн уламжлагч нарын 7 ай тус бүрээр газарзүйн тархалтын зураг


❖ Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд




❖ Ардын язгуур урлаг ай сав




❖ Уламжлалт арга ухаан ай сав



❖ Уламжлалт гар урлал ай сав




❖ Уламжлалт баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуулага






❖ Мал маллах арга ухаан ай сав



❖ Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл



### III. Судалгаа, үйл ажиллагааны тайлан, дүгнэлт

3.1 Сүхбаатар аймгийн СББӨ-ийн онцлох ай, өвийн төрлүүд түүхэн хөгжлийн үйл явцтай гүнзгий холбоотой юм. Одоогийн Сүхбаатар аймгийн нутагт 1697 онд Манж Чин улсын эзэн хааны зарлигаар анх адуун сүрэг байгуулсан бөгөөд одоо ч Сүхбаатар аймаг нь хурдан угшлын адуу ихтэй, улс, аймаг, бүсийн хэмжээний уралдаанд Сүхбаатарын угшилтай адуу үзүүр түрүүнд хуралдаг нутаг билээ. Мөн Дарьганга хошуу эртнээс дархан урлалаар алдартай байсан нутаг билээ.

- Уламжлалт гар урлал үүнд Дарьганга дархны урлал, Сүхбаатар аймаг мод багатай газар хэдий ч модон сийлбэр урлал, эсгий ширмэл урлал голлож байна.
- Мал маллах уламжлалт арга ухаан ай дотор Адууны соёл Сүхбаатар аймагт өргөн дэлгэр тархсан ба адуу маллах арга ухаан, хурдан морь уях сойх мэдлэг, хурдан удмын адуу шинжих мэдлэг, адуучин залуу тэнцээн, морь мал хатгах мэдлэг ухаан зэрэг адуутай холбоотой зан үйл өв уламжлал бүхэлдээ өргөн тархсан байна
- Ардын язгуур урлагийн ай сав дотор Морин хуур хөгжим урлал, морин хуурын татлага, Урдын дуу зэрэг онцлох өвийн төрлүүд байна.

3.2 Сүхбаатар аймгийн СББӨ-ийн онцлох өвлөн уламжлагчид (ай тус бүрээс 2 өвлөн уламжлагчийг дэлгэрэнгүй бичих)

#### **Уламжлалт гар урлал / Дарьганга дархны мөнгөн аяга урлал/**

- Овог нэр: Нацаг овогтой Амартайван
- Харьяалал: Сүхбаатар аймаг Баруун-Урт сум шилжин ирсэн угуул нутаг нь Дарьганга
- Ай сав: Уламжлалт гар урлал
- Өвийн нэр: Монгол дархны уламжлалт арга ухаан
- Гурав дугаар үеийн өвлөн уламжлагч
- Бүрэн дунд боловсролтой Төрөөс авсан гавьяа шагнал: Алтангадас одон

Дарьганга нутгийн алдартай 2 уран дархан байсан нь Дондов дархан, Зундуй дархан нар юм. Үүнээс Зундуй дарханы ач хүү Амартайван нь өвөө, авга ах нараас дархан урлалын арга техник уламжлан авч одоо Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд амьдарч байна.

*Дарьганга дархнууд үндэс, завьяа, шаазанг мөнгөлөн бага дунд их гарын гурван хэмжээгээр мөнгөлдөг ба туурга бөөрөнд хөөмөл, бураа хээ, 8-12 нүдний өлзий хээ, цэцгэн хээ, найман тахил, бад цэцэг болон 12 жилийн гурван хос лууг үүлэн хээнд хөдөлгөн шүр, суулган урлаж амсрыг хамар ба шоргоолжин хумсан хээгээр эмжиж, ёроолын хүнхэрт хос болон дан луу арслан буга хангардийг үүлэн толгой ба өвсөн угалзанд эргэн хөдөлгөж байгаагаар урлаж дотор талд нь түмэн наст хээгээр давхарлан хээлж заримдаа алтан шармалдан урладгаараа хосгүй билээ.* “Сүхбаатар аймгийн түүхэн товчоон 2022 он” Одоо үед техник технологийн хөгжлийг дагаад хятадаас мөнгөн аяга хээлэх машин орж ирсэн бөгөөд гараар цохилуураар хийж урлах нь ховордсон байна.

Амартайван дарханы хувьд уламжлалт цохилуур ашиглан мөнгө аяга урладаг бөгөөд Улаанбаатар хотод Дарьганга хийц гэсэн нэрээр машинаар хээлсэн аяга зарагдах болсонд хамарсан буйгаа хэлсэн юм. Хийц загвар хээ дурайлгаж машинаар хээлээд зарж буй нь аажимдаа уламжлалт гар аргаар цохилуур ашиглан дархан урлал хийх ардын уламжлалт технологи мэдлэг ухаанд хортой болох ба мартагдах аюултай дээр Дарьганга дархан урлалын мэдлэг ухаан цаашид өвлөн үлдэх хүн байхгүйд мөн санаа их зовниож байна.

Дархан урлал нь алт мөнгө үнэт чулуу шаардлагатай хөрөнгө зарсан ардын уламжлалт мэдлэг ухаан учир өөрийн хийсэн мөнгөн аяга тэр бүр өөртөө хадгалж үлдэх боломжгүй ихэнхдээ захиалгаар урлаж буй тул түүний мөнгөн аяга хийцтэй танилцах баримтжуулалт хийх зорилгоор орон нутгийн музейд хадгалагдаж буй түүний мөнгөн аягуудыг музей захиргаанаас зөвшөөрөл авсны үндсэн дээр баримтжуулсан болно.

Монгол дархан урлал тэр дундаа Дарьганга хийц алдартай бөгөөд одоо үед үйлдвэрийн аргаар бизнесийн ашиг сонирхлоор энэ хоёр хийцийг хольж мөнгөн аяга үйлдвэрлэх болсон нь уламжлалт хийц загварын эвдээд зогсохгүй, билэгдэг зүйн утга агуулгыг ч мөн алдагдуулж буйг мөн тэрээр хэлсэн юм. Иймд Амартайван дарханыг онцлох өвлөн уламжлагчаар зориуд нэр цохон санал болгож байна.



### **Жамсран овогтой Уранбилэг /Монгол дархны уламжлалт арга ухаан/ дарьганга эмээл**

- Овог нэр: Жамсран овогтой Уранбилэг
- Харьяалал: Сүхбаатар аймаг Баруун-Урт сум
- Ай сав: Уламжлалт гар урлал
- Өвийн нэр: Монгол дархны уламжлалт арга ухаан
- 1-р үеийн өвлөн уламжлагч

- Бүрэн дунд боловсролтой
- Төрөөс авсан гавьяа шагнал: Алтангадас одон

Сүхбаатар аймаг Дарьганга хийцийн эмээл Дарьганга дархан урлал нь эртнээс алдартай хэдий ч Сүхбаатар аймгийн 11 сумаар явахдаа маш цөөхөн дархнуудтай таарсан бөгөөд нутагтаа үлдсэн цөөн хэдэн дархны нэг бол Уранбилэг гуа юм. Уранбилэг гуа хувьд удам дамжсан дархан биш бөгөөд өөрийн хүсэл сонирхолдоо хөтлөгдөн дарьганга хийцээр эмээл хийх урлах болсон байна. Тэрээр Батноров Дарьганга аль ч хийцээр эмээл урлаж хийдэг ба уламжлалт арга технологийн дагуу хийхийг эрмэлзэж байна. *Дарьганга хийцийн эмээл нь ноён сэрвэй, далай чойнхор, боржигин төв халхын хийцийн мөнгөн эмээлийн хэрэглэл 6-8-12 цагаанд уран гоё тоонолжин болон цэцэг навчин хээг түгээмэл урладаг. Эмээлийн баавар туургыг өмнө нь намхан урладаг байсан бөгөөд 1940 оноос хойш хээ цохидог болсон байна. Хярын цагааныг урлахдаа 2 хашлаганы дотор талыг хос урлаж хөөж, 2 үзүүр үлдээж, хүнхрийг давхар алхан хээ цоолборлож цэцгэн голтой өвсөн угалзыг урладаг. “Сүхбаатар аймгийн түүхэн товчоон 2022 он”*

Уранбилэг дархан Батноров хийцээр эмээл давхар урлаж сурсан шалтгаан нь дарьганга хийцийн эмээлийн мөнгө нь хөөмөл байдаг тул жин багатай гээд хүмүүс сонирхох нь бага харин Батноров хийцийн эмээлийн мөнгө нь цутгамал тул хүмүүс их сонирхож авдаг гэсэн юм. Тэрээр одоо Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд амьдардаг бөгөөд мөн л өөрийн дархан нь дарханы урлалд зориулан 2 давхар байшингаа урлан болгож өөрчлөөсөн бөгөөд ур чадвартаа бүрэн төгс эзэмшсэн байдал, тогтвортой үйл ажиллагаа явуулж буй зэрэг нь СББӨ-ийн өвлөн уламжлагчаар бүртгэх нөхцөлийг хангалттай хангаж байна гэж үзэн шинээр өвлөн уламжлагчаар бүргэлд хамруулсан болно. Мөн Сүхбаатар аймгийн голлох өв /брэнд гэж хэлж болох / болох дархан урлал, дархчуудын нутагтаа тасрах гэж буйд харамсалтай санагдсан болно. Иймд орон нутгийн нөхцөл байдлыг харгалзан онцлох өвлөн уламжлагчаар Уранбилэг дарханыг бүртгэхийг санал болгож байна.



## **Мал маллах уламжлалт арга ухаан ай дотор**

Овог нэр: Дамбийжанцан овогтой Пүрэвсүрэн “аймгийн алдарт уяач”

Харьяалал: Сүхбаатар аймаг Баяндэлгэр сум

3-р үеийн өвлөн уламжлагч

Ай сав: Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл

Өвийн нэр: Хурдан морь уяа сойх, уралдуулах мэдлэг

Төрөөс авсан гавьяа шагнал: Тэргүүний ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медаль  
Малчин

Хурдан морины уяа сойлго тааруулах мэдлэг: Дамбийжанцан овогтой Пүрэвсүрэн  
Аймгийн алдарт уяач,

*Одоогоос 200 –гаад жилийн тэртээ цэцэн хан хурдан хүлгүүд гэж түүхэнд тэмдэглэгдсэн ба Богдын даншиг наадам, ардын хувьсгалын томоохон ойн наадмуудад Сүхбаатар аймгийн зарим хошууны нутгаас Далай вангийн “алдарт цоохор”, “зандан хүрэн”, “элбэг хээр”, “баглаа хээр”, “хүүхдийн хээр”, “жаахан шарга” хожим “Л.Дандарын алаг” нэгдлийн үед “нийгмийн алаг” зэрэг түүхэнд домог болон үлдсэн алдартай хүлгүүд тодорчээ. 1930-1940 оны үед мөн цэргийн агт хэлбэрээр газар газрын адуу, 1940-1950 оны үед аргалын ацан нэрээр Галшар адуу тус аймагт олноор орж ирсэн нь нутгийн адуун сүрээг цус холилдож сайжрахад ихээхэн нөлөө үзүүлсэн байна. Сүхбаатар нутгийн адуу тал хээрийн цаг ууртаа ихээхэн зохицсон ерөнхийдөө жижгэвтэр биетэй өвчинд өртөмтгий биш унаа эдэлгээ даахдаа гарамгай байдаг бөгөөд энэ нутагт хурдаг угшил олон бий. Дурдвал Дарьганга жижиг зээрүүд, Орлой угшил, Ширээтийн цагаан адуу, Баглаа хээр, Банзан хүрэн, Болдын орог саарал, Гомбын соно саарал, Зандан хүрэн, Жамцын хэнгэрэг хээр, Тосон халзан, Шингэн хүрэн, гэх мэт. “Сүхбаатар аймаг түүхэн товчоон 2022 он”*

Адуу хурдан байх нь хурдан угшлаас хамаарахаас гадна адуу шинжих уламжлал мэдлэг ухаан, уяа сойлго таруулах уяач хүний чадвараас ихээхэн хамаарах бөгөөд Сүхбаатарын адуу зөвхөн хурдан угшлаас гадна адуучин малчин ардын уламжлалт мэдлэг сайн өвлөн уламжлагдсан нь гарцаагүй билээ. Иймд бид Сүхбаатар нутгийн СББӨ-ийг үзлэг судалгаа хийж буй тул хурдан морины уяа сойлго тааруулах адуу маллах мэдлэг ухаан, өв уламжлал сайтай аймгийн хувьд аймгийн алдарт уяач Пүрэвсүрэнтэй уулзаж адуу шинжих мэдлэг ухаан, уяа сойлго хэрхэн таруулдаг адуу маллах арга ухааны талаар судалгаа хийсэн юм.

Адуучин хүний хувьд Пүрэвсүрэн гуатай бид хурдан морь шинжих ардын мэдлэг ухаан болон уяа сойлго таруулах адуу малаа хайрлах уламжлалт зан заншил тухай ярилцсаны дээр адуучин уяач нарт тулгарч буй бэрхшээлийн талаар мөн яриа өрнүүлэв. Түүний хувьд тулгарч буй бэрхшээл нь эрлийз адуу болон хурдан морь унаач хүүхдүүдийн талаар нийгмийн сөрөг хандлага уламжлалт зан заншил соёлоо хадгалан хамгаалахад сөрөг нөлөөтэй болохыг дурдсан юм.

1990-ээд оноос хойш Монголд адуу уяж сойх уралдуулах нь зах зээлийн харилцаанд орж улс бүсийн баяр наадамд хурдан адуунууд хүч сойн уралдуулах болсон бөгөөд үүнээс үүдэлтэй гарч ирсэн сөрөг нөлөө нь адууг хурд хүч нэмэх бэлдмэл тэжээл өгч өсгөх, уламжлалт байдлаар адуу маллах арга унаахыг алдагдуулж буйд санаа зовниож буйг мөн хэлсэн билээ. Тэрээр адуу маллах уяж

сойхдоо гарамгай бөгөө мэдлэг ухаанаа өөрийн үр хүүхдүүддээ өвлүүлэх уламжлуулан хадгалж яваа нь онцлох өвлөн уламжлагчаар санал болгох шалтгааныг бүрдүүлсэн билээ.



- Овог нэр: Батдорж овогтой Ганбаатар
- Харьялал: Сүхбаатар аймаг сүхбаатар сум
- 2-р үеийн өвлөн уламжлагч
- Ай сав: Уламжлалт арга ухаан
- Өвийн нэр: Мал хатгах мэдлэг ухаан
- Төрөөс авсан гавьяа шагнал: байхгүй

Батдорж овогтой Ганбаатар 2 үеийн өвлөн уламжлагч Мал хатгах уламжлалт мэдлэг ухааныг ааваас заалгаж өвлөн авсан.



## II. Ардын язгуур урлаг

- Овог нэр: Лувсан овогтой Цэдэвсүрэн
- Харьялал: Сүхбаатар аймаг Баруун-Урт сум шилжин ирсэн , угуул нутаг Дарьганга
- Ай сав: Ардын язгуур урлаг
- Өвийн нэр: Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг “Дарьгангын 6 –н татлага”
- 3-р үеийн өвлөн уламжлагч
- Төрөөс авсан гавьяа шагнал: Алтан гадас одонт
- Хөгжмийн багш мэргэжилтэй

Лувсан овогтой Цэдэвсүрэн гуа насаараа морин хуур хөгжил тоглож, олон шавь төрүүлсэн бөгөөд даригангын морин хуурын 6 татлагыг бүгдийг татаж чаддаг цор ганц өвлөн уламжлагч юм. Сүхбаатар аймагт морин хуур хөгжил түгээмэл өргөн дэлгэрсэн боловч даригангын 6 –нь татлагыг бүгдийг нь татаж буй хүн Цэдэвсүрэн гуа -аас өөр байхгүй тул түүний онцлох өвлөн уламжлагчаар санал болгож байна. Мөн тэрээр орон нутагт морин хуур хөгжим дэлгэрүүлэх үйлст идэвхтэй бөгөөд олон арван морин хуурч нарыг төрүүлсэн багш хүн юм.



- Овог нэр: Балдан овогтой Махгал
- Харьялал: Сүхбаатар аймгийн Халзан сум
- 1-р үеийн өвлөн уламжлагч
- Ай сав: Ардын язгуур урлаг
- Өвийн нэр: Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг
- Түүхийн багш мэргэжилтэй
- Төрөөс авсан гавьяа шагнал: Алтангадас одон



- Овог нэр: Жигжидсүрэн овогтой Жамсран
- Харьлал: Сүхбаатар аймаг Түвшинширээ сум
- 1-р үеийн өвлөн уламжлагч
- Өвийн нэр: Морин хуур хөгжмийн урлал Жамсран гуа Морин хуур хөгжмийн түүх бэлгэдэл зүй утга агуулгыг маш сай судалж мэдсэн, хуур хөгжим хэрхэн урлах арга ухааныг хойч үедээ өвлүүлэн уламжлуулж буй онцлох ёстой өвлөн уламжлагч юм.





- Овог нэр: Чулуунбаатар Энхтөр
- Харьяалал: Сүхбаатар аймаг Баруун-Урт сум
- Ай сав: Уламжлалт гар урлал
- Өвийн нэр: Модон сийлбэрийн урлал
- 2-р үеийн өвлөн уламжлагч
- Төрөөс авсан гавьяа шагнал: байхгүй

Сүхбаатар аймгийн модон сийлбэр урлал онцолго хэв шинжийг харуулсан уламжлалт ухмал сийлбэрлэх аргаар олон хоног ур ухаан шалгаан хийдэг нь онцлогтой.



- Овог нэр: Дорждэрэм Тэгшбаяр
- Харьяалал: Сүхбаатар аймаг Онгон сум
- Ай сав: Уламжлалт гар урлал
- Өвийн нэр: Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал
- 2-р үеийн өвлөн уламжлагч
- Төрөөс авсан гавьяа шагнал: байхгүй



- Овог нэр: Чойжоо овогтой Цолмон
- Харьялал: Сүхбаатар аймаг Эрдэнэцагаан сум
- Ай сав: Уламжлалт арга ухаан
- Өвийн нэр: Арьс, шир боловсруулах уламжлалт арга
- 3-р үеийн өвлөн уламжлагч
- Төрөөс авсан гавьяа шагнал: байхгүй
- Мэргэжил: малчин

Цолмон гуа арьс шүүлэх уламжлалт технологийн дагуу боловсруулан, эсгий хийж өөрийн ахуй амьдралд нутаг оронд үлгэр жишээ болохоор соёлын бүтээлч үйлдвэрлэл болгон хэрэгжүүлж чадсан хүн юм.



- Овог нэр: Наваандорж овогтой Лувсанцэрэн
- Харьяалал: Сүхбаатар аймаг Уулбаян сум
- 2-р үеийн өвлөн уламжлагч
- Ай сав: Ардын язгуур урлаг
- Өвийн нэр: Үзэмчин-Дарьганга уртын дуу
- Бүрэн бус дунд боловсролтой
- Төрөөс авсан гавьяа шагнал байхгүй



- Овог нэр: Мажиграгчаа овогтой Улаан
- Харьяалал: Сүхбаатар аймгийн Онгон сум
- Ай сав: Ардын язгуур урлаг
- Өвийн нэр: Дарьганга богино дуу
- Мэргэжил: дуучин
- Төрөөс авсан гавьяа шагнал: Алтангадас одон



- Овог нэр: Чүлтэм овогтой Жанжаа
- Харьяалал: Сүхбаатар аймаг Түмэнцогт сум
- Ай сав: Ардын язгуур урлаг
- Өвийн нэр: Бүүвэйн дуу
- Боловсрол: Бүрэн бус дунд
- Төрөөс авсан гавьяа шагнал: Жуух бичиг

Жанжаа гуа бүүвэйн дуу нь мартагдсан бүүвэйн дуу, хог хошин дуу олон мэдэх бөгөөд эдгээр дууг дахин сурвалжлан тусгайлан судлах шаардлагатай юм.



- Овог нэр: Борхүү овогтой Энхмаа
- Харьяалал: Сүхбаатар аймаг Дарьганга сум
- Ай сав: Уламжлалт гар урлал
- Өвийн нэр: Монгол зургийн урлал
- Мэргэжил: Зураач
- 1-р үеийн өвлөн уламжлагч
- Төрөөс авсан гавьяа шагнал: Тэргүүний ажилтан

Энхмаа Монгол зургийг аргаар олон жил өөрийн уран бүтээлийг туурвисан аймгийн хэмжээнд урдаа барих шилдэг уран бүтээлч бөгөөд Дарьганга суманд шилжин ирснээс хойш сумын ерөнхий боловсролын сургуульд зургийн багшаар ажиллаж Монгол зургийн арга техникийн сурагчдадаа зааж буй нь онцлох өвлөн уламжлагч хэмээн тодотгов.



- Овог нэр: Гаваа овогтой Даамаа
- Харьяалал: Сүхбаатар аймаг Баяндэлгэр сум
- Ай сав: Уламжлалт арга ухаан
- Өвийн нэр: Бариа заслын аргаар анагаах арга ухаан
- Мэргэжил: Эмч
- 1-р үеийн өвлөн уламжлагч
- Төрөөс авсан гавьяа шагнал: Алтангадас одон

Даамаа гуа эмч мэргэжлээр олон жил ажилсан ба уламжлалт анагаах ухааны чиглэлээр мөн суралцан төгсөж, монголчуудын ардын уламжлалт анагаах ухааны мэдлэгийг өвлөн авч орон нутгийн ард иргэддээ тусгай зөвшөөрөлтэйгөөр эмчилгээ хийдэг юм. Мөн өөрийн түвшинд уламжлалт эмийн ургамал түүний анагаах чадварыг судлан өрнө дорно дахины анагаах ухааны мэдлэгтэй уялдуулан эмчилгээ хийдэг болно. Тэрээр уламжлалт анагаах ухааны мэдлэгийг зөвхөн ашиглахгүйгээр өрнө дорнын анагаах ухааны мэдлэгтэй уялдуулан ард түмэнд хор нөлөөгүйгээр судалгаатай хөгжүүлж буй тул түүнийг онцлох өвлөн уламжлагч хэмээн тодотгон бичлээ.



- Овог нэр: Ядамсүрэн овогтой Цолмонсүрэн
- Харьяалал: Сүхбаатар аймаг, Сүхбаатар сум
- Ай сав: Уламжлалт арга ухаан
- Өвийн нэр: Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга
- 3-р үеийн өвлөн уламжлагч
- Төрөөс авсан гавьяа шагнал байхгүй

Цолмонсүрэн өвлөн уламжлагч нь нутгийн айл саахалт ах дүү айлуудтай хамтран Сүхбаатар нутгийн уламжлалт аргаар цагаан идээ боловсруулан өрхийн бизнес эрхлэн худалдан борлуулдаг бөгөөд тэрээр Сүхбаатар нутгийн брэнд бүтээгдэхүүн болгон нутгийн нэрмэл гарган худалдаалахаар ажиллаж байна. Өөрийн гэр бүлийн багачууд хүүхдүүдээ багаас нь цагаан идээ боловсруулах арга ухаанд сургаж буй тул түүнийг онцлох тэмдэглэж байна.



### **3.3 СҮХБААТАР АЙМГИЙН СББӨ-ИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, СУДАЛГААНЫ УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ**

Сүхбаатар аймгийн хувьд СББӨ-ийн улсын үзлэг судалгааны ажлын үр дүнд нийт бүртгэлтэй 312 өвлөн уламжлагчаар бүлэглэсэн түүврийн аргаар 79 өвлөн уламжлагчийг баримтжуулан судалгаа авсан болно. Бүлэглэсэн түүвэр сонгох болсон шалтгаан нь нэгд хугацаа богино буюу нийт 22 хоног, хоёрт бүлэглэсэн түүвэр хийснээр Сүхбаатар аймгийн түгээмэл дэлгэрсэн өвийг давхардуулахгүйгээр чанартай байдлаар баримтжуулалт хийх боломжтой болох учир түүвэр хийсэн болно. Анхны түүвэрт орсон 11 сумын 102 төрлийн өвөөс 79 бүртгэж баримтжуулсан бөгөөд СББӨ-ийн өвлөн уламжлагч нарын улсын бүртгэл мэдээлэл нь орон нутгийн бүртгэлийн сангийн бүртгэлтэй зөрөх зарим өвлөн уламжлагч нар шилжсэн, нас барсан байх тохиолдол таарсан болно.

Сүхбаатар аймгийн СББӨ-д хийсэн цахим судалгааны тоон болон аналитик үзүүлэлт нэгтгэн дүгнэлт хийвэл Халх угсаатан 44 хүн Дарьганга угсаатан 39 хүн Үзэмчин 4 хүн хамрагдаж угсаатны бүлэг хамрагдаж бусад угсаатны бүлгээс 2 хүн хамрагдсан байна, Мөн үзлэг судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагч нарын 96 хувь нь аймгийн угуул, 75 хувь нь сумын угуул иргэд байна. Насны бүтцийн хувь 60-80 насны иргэд хамгийн олон буюу 30 хувь эзэлж байна. Мөн 46-60 насны 25 дээш хувь, 36-45 хувь нь 10 гарам хувь, харин 80 аас дээш насны хүн хамгийн бага 7 хувь байна. Боловсролын түвшнээр авч үзвэл нийт судалгаанд хамрагдсан хүний 50 хувь нь бүрэн дунд болон, бүрэн бус дунд бөгөөд дээд боловсролтой өвлөн уламжлагч 23 хувь бага боловсролтой 25 хувь байна.

Ажил мэргэжлийн хувьд 23 хувь нь малчин иргэд бөгөөд 43 хувь нь тэтгэврийн насны иргэд, дөнгөж 16 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч бөгөөд өвлөн уламжлагч нарын орлогын эх үүсвэр нь цалин тэтгэвэр малаас хүртсэн ашиг шим давамгай байна. Ийм учир төрөөс СББӨ-ийн өвлөн уламжлагч нарт төрөөс тодорхой дэмжлэг шаардлагатай хэмээн хариулсан бөгөөд өрхийн эдийн засагт нөлөөлдөггүй 50 хувь нөлөө багатай гэж 15 хувь нь хариулсан бол маш хангалттай нөлөөлдөг гэж ердөө 4 хувь нь үзсэн байна.

СББӨ-ийг орон нутагтаа эдийн засгийн эрэлтэд оруулах шаардлагатай хэмээн хариулжээ. СББӨ-ийн өвлөн уламжлагч нар дундаа ардын язгуур урлагтай холбоотой өвлөн уламжлагч нар нь өвөөс хүртэх ашиг орлого гэх зүйл байхгүй бөгөөд цаашид эдгээр өвлөн уламжлагч нартаа тодорхой дэмжлэг үзүүлэх шаардлагатай мэт санагдсан. Мөн судалгаанд хамрагдсан өвлөн уламжлагч нарын 68 хувь нь угийн бичиг хөтөлдөггүй хэмээн хариулсан бөгөөд энэ нь Сүхбаатар аймгийн угсаатны бүлгийн түүхэн бүрдэлтэй холбоотой байж болно.

Дарьганга хошууны хүн ам нь 3 төрөл мал сүрэг захирах, адуулж маллах ба үйлчилгээний хүмүүсээс бүрдэх бөгөөд албаны хүмүүсийн эхнэр хүүхэд, эцэг эх болон албанд өртдөггүй хүмүүсийг сул хар гэдэг байв. Мөн Монголын бусад чуулган хошуудтай адил үе залгамжлах ноёд тайж, хамжлага гэж байгаагүй бөгөөд одоогийн Баяндэлгэр, Халзан, Асгат, Дарьганга, Наран, Онгон сумын нутаг бүхлээрээ Дарьгангын хошуунд харьяалагдаж байжээ. Хожим Их жанжин

Сүхбаатарын өлгий нутаг учир ардын хувьсгалын үйл хэрэгт идэвхтэй бөгөөд хуучин феодал ёсны уламжлалыг таягдан хаях үзэл суртал хүчтэй дэлгэрсэн тээ холбоотой байх магадлал өндөр.

СББӨ-ийн тогтвортой байдал хойч үедээ уламжлуулах байдал нь 68 хувь нь эцэг эх гэр бүлийн хүрээнд өвлөн уламжилсан ба 2-3 дах үеийн өвлөн уламжлагч нарын 56 хувь 3 –аас дээш үеийн өвлөн уламжлагч 15 хувь байна. Дархан урлал уран дарханаас бусад өвийн хүрээнд өвлөн уламжлуулах үйл явц харьцангуй тогтвортой байна. Сүхбаатар аймгийн СББӨ-ийн онцлох өвийн айд нэгдүгээрт: Уламжлалт гар урлал” үүнд Дарьганга дархан урлал, модон сийлбэр урлал, эсгий ширмэл урлал, арьс суран эдлэл голлож байна. Хоёрдугаарт “Мал маллах уламжлалт арга ухаан ай” дотор хурдан морь адуутай холбоотой зан үйл өв уламжлал бүхэлдээ өргөн тархсан бол гуравдугаарт “Ардын язгуур урлагийн ай” дотор Морин хуур хөгжим урлал, морин хуурын татлага, ардын хөгжим, Урдын дуу зэрэг онцлох өвийн төрлүүд байна.

Орон нутгийн хэмжээнд өвлөн уламжлагч нарыг эдийн засаг санхүүгийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх соёлын бүтээлч үйлдвэрлэл нэвтрүүлэх, Өвийн төрөл бүтээгдэхүүн үйлдвэрлэж өрхийн орлого нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд олон бөгөөд үүнд голцуу уламжлалт цагаан идээ боловсруулах арга ухаан, эсгий хийх, эсгий ширмэл урлал, суран эдлэл, модон эдлэл зэрэг төрлүүд голчлон хамрагдсан байна. Сүхбаатар аймаг нь дархан урлал, хурдан морины соёлын биет бус өвөөр Монголдоо алдартай нутаг орон боловч сүүлийн жилүүдэд дархан урлал орхигдож орон нутагтаа дархнууд тогтохгүй байгаа нь бодлогоор анхааран үзэх шаардлагатай мэт.

Хурдан морины соёл сайн хадгалагдан үлдсэн нь эдийн засгийн эргэлт сайтай орон нутаг нь өөрөө /Сүхбаатарын хурдан угшлын адуу нь/ зах зээлд брэнд болж чадсантай холбоотой бол харин дархан урлал нь эдийн засгийн хувьд эрэлт ихтэй бараа бүтээгдэхүүн биш дээр нь олон хүнтэй төв хот суурин газар бараадаж байж худалдаалан борлуулах боломжтой дээр дарханы ур чадвараар олонд танигдаагүй дархнуудын хувьд нутаг орондоо дархан урлал хийж амьдрах нөхцөл боломжгүй болгож байгаа юм. Бидний онцолсон 2 дархан бол нутаг орондоо төдийгүй улсдаа ур хийцээр танигдсан учир хот газар бараадаж шилжин суурьших шаардлагагүй захиалгаар дархан урлал хийдэг тул нутаг орондоо тогтон амьдран байгаа хэрэг билээ.

Сүхбаатар аймгийн соёл урлагийн газар идэвх хичээл зүтгэл сайтай залуу боловсон хүчнээс бүрдсэн хамт олон бөгөөд хээрийн судалгааны 22 хоногийн турш харилцаа холбоо сайтай байж очсон сум бүр дээр СББӨ-ийн өвлөн уламжлагч нартаа холбох уулзуулах ажлыг сайн зохион байгуулсан хэмээн дүгнэж байна.



## ЗӨВЛӨМЖ

Нэгд: Улсын Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч нарын бүртгэл мэдээлэлтэй орон нутгийн Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч нарын бүртгэлийг тулгах засварлах цэгцлэх.

Хоёрт: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаарх төсөл хөтөлбөрт хэрэгжүүлэх дархан урлал дархнууддаа хамруулах, Орон нутгийн хэмжээнд өвлөн уламжлагч нар тасрах аюул буй болох, хот суурин газраас хол боловч Дарьганга дархан урлалыг нийтэд сурталчлах, Нутгийн brand merchandise болгон цөөн тоогоор, онлайн захиалга авч үйлдвэрлэн борлуулах байдлаар эдийн засгийн эргэлт үүсгэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой юм. Үүний үр дүнд дархан урчууддаа өгөөжтэй дээр уламжлалт хэв загвар алдагдахгүй, эдийн засгийн эргэлт үүсвэл дараагийн үе тасрахгүй гэх зэрэг давуу талыг үүсгэх боломжтой үүнтэй төстэй жишээ бол Энэтхэг балбын орон нутгийн дархнууд хамтран орон нутгийн өөрийн алдартай үнэт эдлэлийн брэнд үүсгэсэн түүх байдаг. Омёки нь аль болох нутгийн зан заншил, уламжлалыг чандлан баримтлахыг эрмэлздэг. Энэтхэг, Балбын уламжлалт ноу-хауг урлах ухааныг хүндэтгэдэг бөгөөд сурталчлах хандлагатай байдаг. Тэд уламжлалт аргаар хийсэн үнэт эдлэлээ олонд таниулан хүний гараар хийсэн өвөрмөц бүтээлийг маш цөөн тоогоор захиалгаар үйлдвэрлэн нь зах зээл эргэлттэй болгосон байдаг. Үр дүнд гар урлаачид бүр хийсэн ажлынхаа таашаал ханамж эдлэх хайр халамжаар хийгддэг ажил болсон юм. Дарханы урлал нь өөрөө өртөг зардал өндөртэй СББӨ-ийн төрөл тул зах зээл маркетинг менежментийн тодорхой мэдлэг олгохгүй бол өвлөн уламжлагч нар маань өрсөлдөх чадвар сул тул хятадын дуураймал, үйлдвэрийн аргаар хийсэн дархан урлалын бараа бүтээгдэхүүнд дарагдаж буй юм.

## **САНАЛ**

СББӨ-ийн улсын анхдугаар үзлэг тооллого баримтжуулалт судалгаа хийсэн цаг үеийн нөхцөл байдлаас хамааран зарим СББӨ-ийг үйлдэх цаг хугацаа өнгөрсөн учир баримтжуулах нөхцөл бүрдээгүй дараа дараагийн бүсийн судалгаа дээр улирал цаг агаар зэргийг бодолцох хэрэгтэй гэсэн санал оруулж байна.

## НОМ ЗҮЙ

1. “БНМАУ –ийн ястан угсаатнууд” Х Нямбуу 1992 он
2. “БНМАУ-ийн угсаатан зүйн 1 дүгээр боть” 1987 он
3. “БНМАУ-ийн угсаатан зүйн 3 дугаар боть” 1996 он ном
4. “Дарьганга уулын хошууны хүн амын бүртгэл 1926 он”
5. “Дарьгангын түүхэнд холбогдох баримтууд” Т.Билэгсайхан 2020 он
6. “Сүхбаатар аймгийн түүхэн тойм” 2022 он
7. Дарьганга угсаатны зүй 2007 он Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн
8. 2020 оны Монголын хүн ам орон сууцны нэгдсэн тооллого

# ХАВСРАЛТ

1. Хавсралт 1 - Удирдамж
2. Хавсралт 2 – Дүрс бичлэг фото зургийн товъёог
3. Хавсралт 3 - Шинээр илрүүлсэн өвлөн уламжлагчдын жагсаалт
4. Хавсралт 4 – Соёлын биет бус өвийн үзлэг, судалгааны асуулгын маягт



4  
Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг  
Соёл, урлагийн газрын даргын 2022 оны 07 сарын  
06-ны өдрийн тушаалын гуравдугаар хавсралт

## СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙН ҮЗЛЭГ, БҮСЧИЛСЭН СУДАЛГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

### НЭГ. ЗОРИЛГО

1.1. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.11 дэх хэсэг, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт, Соёлын сайдын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн "Зардал баталж, эрх шилжүүлэх тухай" А/218 дугаар тушаалыг үндэслэн "Соёлын биет бус өвийн үзлэг" (цаашид үзлэг гэх), бүсчилсэн судалгааг зохион байгуулах, СББӨ-ийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх, хадгалалт хамгаалалтын нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах, тархалтыг тогтоох, үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулах, шаардлагатай хэрэглэгдэхүүн, мэдээлэл цуглуулахад оршино.

Зохион байгуулагч: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газар

Хамтран зохион байгуулагч: Соёлын өвийн үндэсний төв, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газар

### ХОЁР. ЗОРИЛТ

2.1. СББӨ-ийн уламжилсан байдал, шилжилт хөдөлгөөн, нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийн нөхцөл байдлын судалгаа хийх;

2.2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Бүртгэл шинэчлэн батлах тухай" 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/759 дүгээр тушаалаар баталсан Соёлын биет бус өвийн Төлөөллийн үндэсний бүртгэл, Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд бүртгэгдсэн өв, өвлөн уламжлагчийн талаар түүвэр судалгаа хийх;

2.3. Тухайн орон нутагт оршин буй үндэстэн, угсаатны бүлэг, СББӨ-ийн төрөл зүйлийг таньж тогтоох, сурвалжлан олох;

2.4. Соёлын биет бус өв, өв тус бүрийн хадгалалт хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдал, эерэг болон сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж тогтоох, дүн шинжилгээ хийх;

2.5. СББӨ болон өвлөн уламжлагчийн тоо, газарзүйн тархалтыг тогтоох;

5. Уламжлалт арга ухаан;
6. Мал маллах арга ухаан;
7. Уламжлалт гар урлал.

(Тушаалын хавсралтыг Соёлын өвийн үндэсний төвийн <http://ncch.gov.mn/method> цахим хуудаснаас татаж авна уу.)

4.2. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд анхан шатны байдлаар бүртгэгдсэн өвлөн уламжлагчийн бүртгэлд тулгуурлан зохион байгуулна.

4.3 СББӨ-ийн үзлэг, бүсчилсэн судалгааг Баруун, Зүүн, Хангайн, Төв, Говийн бүсийн дагуу зохион байгуулж, дараах байдлаар хамрах хүрээг тодорхойлно. Үүнд:

4.3.1 Баруун бүс буюу Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан;

4.3.2 Хангайн бүс буюу Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Булган, Орхон, Хөвсгөл;

4.3.3 Төвийн бүс буюу Сэлэнгэ, Төв, Дархан-Уул;

4.3.4. Говийн бүс буюу Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говь-сүмбэр;

4.3.5 Зүүн бүс болон нийслэл буюу Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Улаанбаатар хот.

## ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

5.1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага СББӨ-ийн үзлэг, бүсчилсэн судалгааны ажлыг цахим болон хээрийн судалгааны аргаар тус тус зохион байгуулна;

5.2. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага үзлэг, судалгааг удирдлага зохион байгуулалтаар хангах "Төв ажлын хэсэг", Баруун, Зүүн бүс болон нийслэл, Хангайн, Төв, Говийн бүсийн нутаг дэвсгэрт ажиллах "Хээрийн судалгааны баг"-ийг тус тус байгуулна;

5.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутагтаа СББӨ-ийн үзлэг, судалгааг зохион байгуулах "Салбар ажлын хэсэг"-ийг байгуулна;

5.4. Үзлэг, судалгааны явцад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр "Төв ажлын хэсэг"-ийн дарга, гишүүд, "Хээрийн судалгааны баг"-ийн ахлагч, судлаач, "Салбар ажлын хэсэг"-ийн дарга, гишүүдийг өөрчилж, чөлөөлөхийг хориглоно;

### **5.5. Төв ажлын хэсэг**

5.5.1. "Төв ажлын хэсэг" нь Баруун, Хангайн, Зүүн, Төв, Говийн бүсийн СББӨ-ийн үзлэг, судалгааг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах, дүн шинжилгээ хийх, судалгаа, тайланг нэгтгэх, тайлагнах, үзлэг, судалгааны ажлын мөрөөр авах арга хэмжээний санал боловсруулах ажлыг удирдан зохион байгуулна;

5.5.2. "Төв ажлын хэсэг" нь хээрийн судалгааны багийг ажлын маршрутыг гаргана;

5.5.3. "Төв Ажлын хэсэг" нь "Салбар ажлын хэсэг"-т баталсан асуулгын маягт 1, 2-ыг 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдөр цахим холбоосоор хүргүүлж, цахим маягыг бөглөх, заавар, сургалтыг зохион байгуулна.

5.5.4 "Төв ажлын хэсэг" нь цахим асуулгын маягт 1, 2-т оруулах мэдээлэл, зохион байгуулах үйл ажиллагаанд хяналт тавьж, "Салбар ажлын хэсэг"-ийг мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.

5.5.5. "Төв ажлын хэсэг" нь ажлын 21 хоног тутамд хуралдаж, "Хээрийн судалгааны баг", "Салбар ажлыг хэсэг"-ээс ирүүлсэн ажлын явц, үр дүнгийн талаарх мэдээлэлтэй танилцаж, холбогдох санал, зөвлөмжийг "Хээрийн судалгааны баг", "Салбар ажлыг хэсэг"-т тус тус хүргүүлж ажиллана;

## **5.6. Хээрийн судалгааны баг**

5.6.1 СББӨ-ийн үзлэг, бүсчилсэн судалгааг зохион байгуулах "Хээрийн судалгааны баг" маршрутын дагуу томилолтоор ажиллахдаа түүврийн болон асуумжийн арга зүйг ашиглана;

5.6.2. СББӨ-ийн үзлэг, бүсчилсэн судалгааг бүсчлэн зохион байгуулах хээрийн судалгааны багийн бүрэлдэхүүнд тухайн орон нутгийн соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дэмжлэг үзүүлж хамтран ажиллах ба Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн "Хээрийн судалгааны баг"-т ажиллана;

5.6.3. Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолоор батлагдсан "Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн үндэсний жагсаалт"-д бүртгэгдсэн өвлөн уламжлагч, Монгол Улсын Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд багтсан өв, өвлөн уламжлагчийн урын сан, уламжлалт мэдлэг ухаан, арга барилыг "Хээрийн судалгааны баг" биечлэн үзэж гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулна;

5.6.4. Гэрэл зургийн нягтаршлыг 300 dpi-аас доошгүй, JPG өргөтгөлтэй авах, дүрс бичлэгийг HD форматаар бичнэ;

5.6.5. Гэрэл зургийн тоо нь 3-с доошгүй /тухайн өвлөн уламжлагчийн холбогдох гэрэл зураг/, дүрс бичлэг нь 5 минутаас доошгүй байна;

5.6.6. СББӨ-ийн оршин тогтнох чадавх, нөхцөл байдлын дүн шинжилгээ, задлан шинжилгээ хийхдээ тоон болон харьцуулалтын аргыг ашиглана;

5.6.7. СББӨ, өвлөн уламжлагчийг гэрэл зураг, дүрс бичлэгээр баримтжуулахдаа тайзны болон уран сайхны, зохиомол байдлаас зайлсхийж, бодит үйл явдал, өрнөл, хөдөлгөөнт дүрслэл бүхий баримтат бүртгэн, баримжуулалтыг хийнэ.

### 5.7. Салбар ажлын хэсэг

5.7.1. Аймаг, нийслэлийн Засаг даргын тушаалаар СББӨ-ийн үзлэг, судалгааг зохион байгуулах “Салбар ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнийг батлана.

5.7.2. Соёлын биет бус өвийн үзлэг хийх журмын 2.5 дахь хэсэгт заасны дагуу бүх шатны Засаг дарга нар “Салбар ажлын хэсэг”-т шаардлагатай дэмжлэг үзүүлж хамтран ажиллана;

5.7.3. Аймгийн “Салбар ажлын хэсэг” нь 5-аас дээшгүй хүний бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Дарга: Аймгийн соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга;

Гишүүд: Аймгийн Засаг даргын тамгын газрын нийгмийн бодлогын хэлтсийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн;

Аймгийн бүртгэл, мэдээллийн сан хариуцсан ажилтан эсхүл орон нутгийн музейн бүртгэл, мэдээллийн сан хариуцсан ажилтан;

Соёлын биет бус өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдын төлөөлөл;

Нарийн бичгийн дарга: Аймгийн соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн.

5.7.4. Нийслэлийн “Салбар ажлын хэсэг” нь 5-аас дээшгүй хүний бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Дарга: Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга;

Гишүүд: Нийслэлийн Соёл, урлагийн газрын Соёлын хэлтсийн дарга;

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн ;

Соёлын биет бус өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдын төлөөлөлөл;

Нарийн бичгийн дарга: Нийслэлийн Соёл, урлагийн газрын соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн.



5.7.5. “Салбар ажлын хэсэг”-ийн дарга нь ажлын хэсгийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангаж, үзлэг, судалгааны ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг батлан, гишүүдийн хариуцах ажил үүргийг тогтооно;

5.7.6. “Салбар ажлын хэсэг”-ийн нарийн бичгийн дарга нь ажлын хэсгийн үйл ажиллагааг баримтжуулах, холбогдох баримт бичгийг цуглуулах, хадгалах, ажлын хэсгийн даргаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг хариуцна;

5.7.7. Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн соёлын асуудал хариуцсан мэргэжилтэн үзлэг, судалгааны ажлыг зохион байгуулахад шаардлагатай дэмжлэг үзүүлэх ажлыг хариуцна;

5.7.8. Соёлын биет бус өвийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдын төлөөлөл нь мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана;

5.7.9. “Салбар ажлын хэсэг” нь Соёлын биет бус өвийн оршин тогтнох чадварыг тодорхойлох зорилгоор баталсан асуулга бүхий маягт, гэрэл зураг, дуу, дүрс бичлэгээр баримтжуулж, дүн шинжилгээ хийх байдлаар зохион байгуулна;

5.7.10. “Салбар ажлын хэсэг” нь СББӨ-ийн үзлэг, судалгааг удирдамжийн 3.2-т заасан хугацаанд асуулгын маягтын дагуу цахимаар зохион байгуулна.

5.7.11. “Салбар ажлын хэсэг” нь [www.ich.mongoluv.mn](http://www.ich.mongoluv.mn) програмд бүртгэлтэй өвлөн уламжлагч нарын мэдээлэлд үндэслэн батлагдсан цахим асуулгын маягт 1-ийн дагуу СББӨ-ийн өвлөн уламжлагч нараас асуулгыг авч мэдээллийг цахим (google form)-д оруулах, бүртгэл хөтлөх, ажлыг зохион байгуулна;

5.7.12. “Салбар ажлын хэсэг” нь СББӨ-ийг хадгалж хамгаалах чиглэлээр зохион байгуулагдсан арга хэмжээний судалгааг батлагдсан цахим асуулгын маягт 2-ын дагуу мэдээллийг цуглуулж цахим (google form)-д оруулна;

5.7.13. “Салбар ажлын хэсэг” нь 2 долоо хоног тутамд хуралдаж, үзлэг, судалгааны ажлын явцын талаар хэлэлцэж, явцыг илтгэх хуудсаар “Төв ажлын хэсэг”-т (цахимаар) ирүүлнэ;

## ЗУРГАА. ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

6.1. Судалгаа, үзлэг, судалгааны ажлыг зохион байгуулахад шашин шүтлэг, нас, хүйс үл хамааран, угсаатны цөөнхийн тэгш оролцоог хангах зарчмын дагуу зохион байгуулна.

6.2. Тухайн бүс нутагт шилжин суурьшсан үндэстэн, угсаатны бүлгийн соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийг тэгш хамруулна;

6.3. Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд анхан шатны байдлаар бүртгэгдсэн СББӨ, түүнийг өвлөн уламжлагчийг тухайн өвийн оршин байгаа газар,

ахуй орчин, шаардлагатай тохиолдолд нэг дор төвлөрүүлэн үзлэг, судалгааг зохион байгуулна;

6.4. Удирдлага зохион байгуулалтаар хангах ажлын хэсэг, Хээрийн судалгааны баг, Салбар ажлын хэсэг нь соёлын биет бус өвийн үзлэг, судалгааны үеэр олж авсан хувь хүн, албан байгууллагын нууцыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу чандлан нууцална;

6.5. Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагч нь үнэ цэнийн хувьд шүүмжлэлээс ангид байна.

6.6. Тухайн соёлын биет бус өвийн үндсэн агуулгыг хувиргах, бүтцийг өөрчлөх, буруу ташаа ойлголт үүсгэхээс сэргийлнэ.

6.7. Өвлөн уламжлагчийн үнэт зүйлс, соёлын хэм хэмжээг хүндэтгэн хүлээн зөвшөөрч, угсаатны өвөрмөц байдлыг хүндэтгэх, жендэрийн тэгш байдалд онцгой анхаарал хандуулна.

6.8. Өвлөн уламжлагтай хамтын ажиллагаа, харилцан яриа хэлэлцээ, зөвшилцөл, зөвлөлдөх зарчмаар судалгаа, үзлэгийг зохион байгуулна.

#### ДОЛОО. СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧДЫГ ТАНЬЖ ТОГТООХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

7.1. Соёлын биет бус өвийг илэрхийлэх арга барил, язгуур хэв шинж, донж маяг, уламжлалыг хадгалсан байх;

7.2. Гүйцэтгэх ур чадвараараа нутаг усандаа алдаршсан байх;

7.3. Тухайн дэг сургууль, арга барилын гол төлөөлөгч, илтгүүр /эталон/ нь байх;

7.4. Соёлын орчин, ахуй зан үйлтэйгээ аль болох уялдсан байх;

7.5. Урын сан, ур чадвар, гүйцэтгэл, онцлогийг илэрхийлэх байдал;

7.6. Сургалт явуулах чадавх, дадлага туршлагатай байх;

7.7. Устаж мөхөхийн босгонд тулсан, яаралтай хамгаалалтад авах шаардлагатай өвийг онцгой харгалзах;

7.8. Тухайн өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөн эзэмшсэн байх;

7.9. Тухайн өвтэй холбогдох эд зүйл, хэрэглэгдэхүүн, хэрэглээ, давтамж зэргийг харгалзан үзнэ. *(өвлөн уламжлагчид нь дээрх шалгуур үзүүлэлтээс 2-оос доошгүй шалгуурыг хангасан байна).*

## Нэрсийн жагсаалт өвийн нэр, Дүрс бичлэг фото зургийн товъёог

| №  | Видео бичлэг гэрэл зургийн код | Өвлөн уламжлагчийн овог, нэр | Өвийн төрөл  |
|----|--------------------------------|------------------------------|--|
| 1  | SB-001-BU                      | Нацаг Амартайван             | Монгол дархны уламжлалт арга ухаан   |
| 2  | SB-002-BU                      | Чулуунбаатар Энхтөр          | Модон сийлбэрийн урлал   |
| 3  | SB-003-BU                      | Ёндон Бадарч                 | Монгол зургийн урлал, хавсарсан өв монгол хээ угалзны бэлгэдэл зүйн мэдлэг ухаан               |
| 4  | SB-004-BU                      | Жамсран Уранбилэг            | Дарьганга дарханы уламжлалт арга ухаан, Шинээр бүртгэлд оруулсан                               |
| 5  | SB-005-BU                      | Жалхаа Бавгар                | Дарьганга богино дуу   |
| 6  | SB-006-BU                      | Лувсан Цэдэвсүрэн            | Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг  |
| 7  | SB-007-BD                      | Галсан Төмөрхуяг             | Ардын сурган хүмүүжүүлэх ухаан   |
| 8  | SB-008-BD                      | Сундуй, Цэнд                 | Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг  |
| 9  | SB-009-BD                      | Гончигсүрэн Гунаасүрэн       | Үлгэр  |
| 10 | SB-010-BD                      | Фушкин Амгаланбаатар         | Мал хатгах уламжлалт мэдлэг, Шинээр бүртгэж оруулсан.  |
| 11 | SB-011-BD                      | Дамбийжанцан Пүрэвсүрэн      | Адуун сүрэг маллах арга ухаан, Хурдан морь шинжих мэдлэг, Хурдан морь сойх, уралдуулах мэдлэг. |
| 12 | SB-012-BD                      | Чулуунхүү Буянхүү            | Үхэр сүрэг маллах мэдлэг ухаан   |
| 13 | SB-013-BD                      | Манлай Шагдаржав             | Монгол зургийн урлал   |
| 14 | SB-014-BD                      | Гаваа Даамаа                 | Ургамалын зүйлээр анагаах арга ухаан, хавсарсан өв: Бариа заслын аргаар анагаах арга ухаан     |
| 15 | SB-015-DG                      | Ням Буяндэлгэр               | Модон сийлбэрийн урлал   |
| 16 | SB-016-DG                      | Ядам Төмөрчулуун             | Мал хатгах уламжлалт мэдлэг шинээр бүртгэлд оруулсан   |
| 17 | SB-017-DG                      | Батсүх Мөнхсайхан            | Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал   |
| 18 | SB-18-DG                       | Сумьяа Урансайхан            | Халх хувцасны уламжлалт урлал  |
| 19 | SB-19-DG                       | Борхүү Энхмаа                | Монгол зургийн урлал   |
| 20 | SB-020-DG                      | Давхай Дугарсүрэн            | Ургамалын зүйлээр анагаах арга ухаан хавсарсан өв: Монгол дархны уламжлалт арга ухаан          |
| 21 | SB-021-DG                      | Зундуй Боргил Баттулга       | Тэмээн сүрэг маллах арга ухаан Шинээр бүртгэлд оруулсан  |
| 22 | SB-022-DG                      | Дондов Батхүрэл              | Монгол дарханы уламжлалт арга ухаан  |
| 23 | SB-023-MKH                     | Арилд Ганбаяр                | Монгол дарханы уламжлалт арга ухаан  |
| 24 | SB-024-MKH                     | Сэнгээ Бат-Орших             | Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг, Монгол хөөмийн уламжлалт урлаг                            |
| 25 | SB-025-O                       | Мажиграгчаа Улаан            | Дарьганга богино дуу   |
| 26 | SB-026-O                       | Дорждэрэм Тэгшбаяр           | Монголын уламжлалт арьс ширэн эдлэлийн урлал   |
| 27 | SB-027-O                       | Дашдорж Ногоондарь           | Төл мал авахуулах уламжлалт мэдлэг ухаан   |

|    |            |                              |  |
|----|------------|------------------------------|--|
| 28 | SB-028-O   | Цэвээн Юмжир                 | Халх хувцасны уламжлалт урлал  |
| 29 | SB-029-O   | Цэнд Нарантуяа               | Эсгий ширмэл урлал   |
| 30 | SB-030-SB  | Цэрэнбалтав<br>Сайнжаргал    | Халх богино дуу  |
| 31 | SB-031-SB  | Бүргэдэй<br>Эрдэнэчимэг      | Цохилуур хөгжим тоглох урлаг   |
| 32 | SB-032-SB  | Баялжинням<br>Амарбат        | Арьс шир боловсруулах уламжлалт арга   |
| 33 | SB-033-SB  | Батдорж Ганбаатар            | Мал хатгах уламжлалт мэдлэг  |
| 34 | SB-034-SB  | Лэгцэг Нарангэрэл            | Шударга хөгжим тоглох урлаг  |
| 35 | SB-035-SB  | Буд Цэнд                     | Хөлөгт ба өрөгт тоглоомын уламжлалт төрлүүд                                      |
| 36 | SB-036-SB  | Чинжээ Амаржаргал            | Халх уртын дуу   |
| 37 | SB-037-SB  | Ядамсүрэн<br>Цолмонсүрэн     | Цагаан идээ бэлтгэх уламжлалт арга   |
| 38 | SB-038-SB  | Гонгорсүрэн<br>Баярмандах    | Халх хувцасны уламжлалт урлал  |
| 39 | SB-039-SB  | Чүлтэм Батхүрэл              | Монголын уламжлалт модон эдлэлийн урлал  |
| 40 | SB-040-TSH | Жамьяанпунцаг<br>Должинсүрэн | Дом  |
| 41 | SB-041-TSH | Жигжидсүрэн<br>Жамсран       | Морин хуур хөгжмийн уламжлалт урлал  |
| 42 | SB-042-TSH | Батсүх, Санжаа               | Аялгуут аман зохиол  |
| 43 | SB-043-TSH | Гомбо Төмөрсүх               | Халх хувцасны уламжлалт урлал  |
| 44 | SB-044-TSH | Равсал Отгончимэг            | Үхэр сүрэг маллах арга ухаан   |
| 45 | SB-045-TSH | Довдондамба<br>Дэчинганаа    | Байгаль хамгаалах уламжлалт арга мэдлэг, зан үйл                                 |
| 46 | SB-046-TSH | Дашзэвэг<br>Далайжаргал      | Үхэр сүрэг маллах арга ухаан   |
| 47 | SB-047-TSH | Төмөрбаатар<br>Хишигдүүрэн   | Эсгий ширмэл урлал, хонины ноос боловсруулах, эсгий хийх уламжлалт мэдлэг ухаан, |
| 48 | SB-048-TSH | Базаррагчаа<br>Энхжаргал     | Мал хатгах уламжлалт мэдлэг у  |
| 49 | SB-049-TTS | Дорж Наранцэцэг              | Ятга хөгжим тоглох урлаг   |
| 50 | SB-045-TTS | Ишээхүү Батгэрэл             | Үзэмчин -Дарьганга уртын дуу   |
| 51 | SB-051-TTS | Балдан<br>Хүрэлбаатар        | Бэлэг дэмбэрэлийн үгс  |
| 52 | SB-052-TTS | Цэгмэд, Даваа                | Эсгий ширмэл урлал   |
| 53 | SB-053-TTS | Жамъяндаваг<br>Эрдэнэтовуу   | Ямаан сүрэг маллах арга ухаан  |
| 54 | SB-054-TTS | Шаравнямбуу Оюун             | Тэнгэр, эрхэс, цаг агаар шинжих уламжлалт мэдлэг                                 |
| 55 | SB-055-TTS | Буд Зоригтбаатар             | Харилцаа дуу   |
| 56 | SB-056-TTS | Жамсран<br>Наранцэцэг        | Шудрага хөгжим тоглох урлаг  |
| 57 | SB-057-TTS | Аюуш Баатархуяг              | Модон сийлбэрийн урлал   |
| 58 | SB-058-TTS | Зана, Гомбо                  | Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг  |

|    |            |                           |  |
|----|------------|---------------------------|--|
| 59 | SB-059-TTS | Ч Жанжаа                  | Бүүвэйн дуу,                                   |
| 60 | SB-060-TTS | Мягмаржав<br>Бямбарагчаа  | Монголын уламжлалт уях зангидах урлал          |
| 61 | SB-061-UB  | Доржготов<br>Ичинхорлоо   | Дом /Энхрий хүүхдийн гэр/                      |
| 62 | SB-062-UB  | Наваандорж<br>Лувсанцэрэн | Үзэмчин Дарьганга уртын дуу                    |
| 63 | SB-063-UB  | Ч.Дэнсмаа                 | Эсгий ширмэл урлал                             |
| 64 | SB-064-UB  | Жамсран Соёлсүх           | Халх уртын дуу, аялгуут аман уламжлал          |
| 65 | SB-065-UB  | Бадам /Шарав/<br>Агваан   | Хурдан морь шинжих мэдлэг,                     |
| 66 | SB-066-UB  | Даваа Шигмэджамц          | Монгол зурхай                                  |
| 67 | SB-067-UB  | Дондог<br>Шижирбаатар     | Шагай харваа                                   |
| 68 | SB-068-KH  | Халзан Отгонтөгс          | Хурдан морины хүүхдийн гийнгоо, марзай         |
| 69 | SB-069-KH  | Балдан Махгал             | Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг            |
| 70 | SB-070-KH  | Ганхүү Мөнхөө             | Ерөөл  |
| 71 | SB-071-ETS | Жүгдэр Сэнгээ             | Хуучир хөгжим тоглох урлаг, домог, хууч яриа   |
| 72 | SB-072-ETS | Алтангэрэл<br>Оюунгэрэл   | Үзэмчин богино дуу                             |
| 73 | SB-073-ETS | Бат-Өлзий<br>Батхолбоо    | Ерөөл, магтаал                                 |
| 74 | SB-074-ETS | Мишигдорж<br>Ганболд      | Лимбэ хөгжим тоглох урлаг                      |
| 75 | SB-075-ETS | Чойнжоо Цолмон            | Арьс, шир боловсруулах уламжлалт арга          |
| 76 | SB-076-ETS | Банзрагч, Мишиг           | Төл авахуулах ая дуудлага, зан үйл             |
| 77 | SB-077-ETS | Дамиран Мөнхөө            | Монгол уламжлалт зан заншил                    |
| 78 | SB-078-ETS | Ундрах, Уртнаст           | Монгол үндэсний уламжлалт, цай ундаа хийх арга |
| 79 | SB-079-ETS | Аюуш Буд                  | Хэлц хэвшмэл үг, шог хошин яриа                |

## Шинээр илрүүлсэн өвлөн уламжлагчдын жагсаалт

| № | Сум        | Овог          | Нэр           | Хүйс    | Ай сав                | Өвийн төрөл                        |
|---|------------|---------------|---------------|---------|-----------------------|------------------------------------|
| 1 | Баруун-Урт | Жамсран       | Уранбилэг     | Эрэгтэй | Уламжлалт гар урлал   | Монгол дархны уламжлалт арга ухаан |
| 2 | Баяндэлгэр | Фушкин        | Амгаланбаатар | Эрэгтэй | Уламжлалт арга ухаан  | Мал хатгах уламжлалт мэдлэг ухаан  |
| 3 | Дарьганга  | Ядам          | Төмөрчулуун   | Эрэгтэй | Уламжлалт арга ухаан  | Мал хатгах уламжлалт мэдлэг        |
| 4 | Дарьганга  | Зундуй Боргил | Баттулга      | Эрэгтэй | Мал маллах арга ухаан | Тэмээн сүрэг маллах арга ухаан     |